

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл

2012. 12 сар. №24 (034)


[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

Гол хөшүүрэг нь иргэдийн  
хүсэл эрмэлзэл

Давалгааг дага

Сонгуулийн эдийн засаг

## УГТАХ БЭЛЭГ





## ЛИМУЗИН ҮЙЛЧИЛГЭЭ

- 👑 Тансаг зэрэглэлийн машин
- 👑 Англи хэлтэй жолооч
- 👑 Төлбөрийн уян хатан нөхцөл
- 👑 Хүүхдийн суудал
- 👑 Хурим, хүндэтгэлийн үйлчилгээ
- 👑 Орон нутагт очиж үйлчлэх боломж



# TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ЭРХЭМ ХҮНДЭТ ХАРИЛЦАГЧ  
ТА БҮХЭНДЭЭ ИРЖ БҮЙ  
ШИНЭ ОНЫ МЭНД ХҮРГЭЭ

## ЦОРЫН ГАНЦ ДАХИН ДАВТАГДАШГҮЙ БЭЛЭГ



Бэлэглэлийн картууд нь банкнаас гаргасан 3-н төрлийн загвартайгаас гадна хэрвээ та хүсвэл өөрийн хүссэн зургаа картын нүүрэн дээр хэвлүүлэн захиалж авах боломжтой юм.



ХХБ-ны харилцагч бол өөрийн одоо ашиглаж буй идэвхитэй дансан дээрээ нэмэн Фото дебит картыг захиалах боломжтой бөгөөд ингэснээр та банкны бүх төрлийн үйлчилгээг өөрийн хүссэн загвартай картаар хүлээн авдаг болох юм.

## 30ш-ээс дээш карт захиалвал

## ХЯМДРАЛТАЙ

Байгууллага хамт, олноороо 30ш-ээс дээш карт захиалсан тохиолдолд үнийн дүнгээс тодорхой хэмжээгээр хямдралтай гэдгийг дуулгахад таатай байна.



www.brb.mn , 7011-9967

A Series 5.2mm HD LED дэлгэц түрээсийн үйлчилгээ нэвтрүүлээ.



МОНГОЛД АНХ УДАА ТҮРЭЭСИЙН  
A SERIES 5.2MM SMD LED  
ДЭЛГЭЦИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

5.2mm  
pixel pitch

1280x768  
resolution



Маш нимгэн  
105mm

SMD  
гэрэлтэй



# FUTURE MONGOLIA

INTERNATIONAL TRADE FAIR AND CONFERENCE FOR SUSTAINABLE DEVELOPMENT

## УРИЛГА

Монгол Улсад хоёр дахь удаагаа зохион байгуулагдах гэж буй

### ”FUTURE-MONGOLIA 2013”

олон улсын зэрэглэлийн үзэсгэлэн яармаг худалдаа, хөгжлийн түлхэц бага хуралд зориулсан “Kick off Meeting” 2013 оны 1 сарын 15 нд Мягмар гаригт 10 цагт Blue Sky зочид буудал, 3 давхарт TOPAZ хурлын танхимд болно.

### FUTURE MONGOLIA 2013

2013 оны зургадугаар сарын 19-22-нд зохион байгуулагдах олон улсын зэрэглэлийн үзэсгэлэн яармаг худалдаа хөгжлийн түлхэц бага хуралд зориулсан “Kick- of- Meeting” арга хэмжээнд хүрэлцэн ирэхийг хүндэтгэлтэйгээр урья.

#### Арга хэмжээнд :

- GEO, VE Messen ХХК -ийн захирал ноён С.Фишер илтгэл тавина
- Хэлэлцүүлэг
- Хэвлэлийн бага хурал
- Хөнгөн зууш

**Холбогдох утас:**  
88064242, 94009471



# COAL MONGOLIA 2013

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

Зохион байгуулагч



УУЛ  
УУРХАЙН ЯАМ



“COAL MONGOLIA-2013” чуулга уулзалт, үзэсгэлэнгийн хүрээнд 2013 оны 2 дугаар сарын 23-ний өдөр “Mongolian Mining Corporation”-ы Ухаа Худаг, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхайтай танилцах аяллыг зохион байгуулах гэж байна.

## БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА

## 2013.02.23



### УХАА ХУДАГ - MONGOLIAN MINING CORPORATION

[www.mmc.mn](http://www.mmc.mn)



## НЭГ УДААГИЙН АЯЛЛААР МОНГОЛЫН ХАМГИЙН ТОМ ХОЁР УУРХАЙТАЙ ТАНИЛЦАНА



### “ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

[www.erdenestt.mn](http://www.erdenestt.mn)



Дэлгэрэнгүй мэдээллийг:

Утас: +976-70115590, Факс: +976-70125590

Э-шуудан: [registration@coalmongolia.mn](mailto:registration@coalmongolia.mn), Веб сайт: [www.coalmongolia.mn](http://www.coalmongolia.mn)



## Шинэ бүхний эхлэл “Эм Ай Эйч” - ЭЭС



Улиран одож буй хуучин он Танд  
Ухаарал баяслыг хайрлаж  
Угтан авч буй шинэ жил Танд  
Урам зориг, аз жаргалын дээдийг бэлэглэг.  
Амжилт бүтээлээр арвин  
Арван таван жилийг хамтдаа бүтээсэн  
Эрхэм харилцагч, “Эм Ай Эйч” группын нийт хамт олондоо  
Ирж буй шинэ оны мэнд хүргэе!



**MINE  
INFO**

**М-СОЛИД**

**БОЛО**

**FSCo**  
Financial Services Corporation

**National Life**

**MIBG**  
Mongolian Investment Banking Group

**NVC**  
National Venture Capital LLC

**RICH POINT LLC**

**ПЕНОХИЙЦ ХХК**

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот,  
Баянгол дүүрэг, Амарсанаагын гудамж,  
Колорадо Бизнес Центр, 308 тоот

**Утас:** 976 - 70149761  
976 - 70141169

**Факс:** 976 - 70149761

**И-мэйл:** info@mih.mn



# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Ж.Түмэнбаяр

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /8880-0825/

Д.Баттулга /9902-2279/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

"ECONOMY" ТВ СТУДИ

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,  
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

## ҮДӨӨҮЯХЭЕІ ҢӨДЭЭ



"Mongolian Economy" сэтгүүл эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх зорилгынхоо хүрээнд ажиллаад хоёр дахь жилээ үдэх гэж байна.

Бидний хувьд 2010-2012 он маш чухал он цагийн хэлхээс байлаа. Эдийн засгийн сэтгүүлийн өнгө аяс ямар байх, нийтлэл, ярилцлагыг хэрхэн хүмүүст хүргэх, өнгө дизайны хувьд ч эрэл хайгуул хийсэн жилүүд байв. Сэтгүүлийнхээ урт хугацаанд оршин тогтнох ирээдүйн үйлсийн үндсийг зөв тавих, уншигч, захиалагчдадаа хэрэгтэй мэдээллийг нь хүргэх чиглэлд багагүй хичээн ажилласан. Үүний үр дүнд сэтгүүл маань тодорхой хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, уншигч, захиалагчдын тоо ч эрс өслөө. Энэ бол сэтгүүлийг, манай хамт олныг үнэлж дүгнэсэн үзүүлэлт хэмээн бид хүлээн авахын зэрэгцээ цаашид улам эрч хүчтэй ажиллах урам зоригийг авлаа.

2013 он, манай хамт олны хувьд мөн чухал жил байх болно. Өнгөрсөн хугацаанд олсон ололт амжилтдаа дөрөөлөн нийтлэлийн бодлого чанараа сайжруулах зорилго тавин ажиллана.

Мөн Монголын хийгээд дэлхийн эдийн засаг, санхүү, бизнестэй холбоотой өдөр тутмын болон тойм мэдээ мэдээлэл, үйл явдал, нийтлэл, ярилцлагыг www.mongolianeconomy.mn сайтаараа шуурхай дамжуулан хүргэж ажиллах болно.

Ингээд сэтгүүлтэй маань хоёр жилийг хамтдаа өнгөрүүлж, биднийг дэмжин ажилласан бүх захиалагч, уншигч болон хамтран ажилладаг байгууллагууддаа шинэ оны мэнд хүргэж, амжилт хүсэхийн зэрэгцээ ирэх онд бидний хамтын ажиллагаа улам батжин бэхжихийн сүүн ерөөл өргөө.

ЭРХЛЭГЧ Д.БЭХБАЯР

## Зайрмагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл



Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм...10

### Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан

Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо. ...16



### Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл



Манай нийслэлээс гарч буй хогны 60 орчим хувийг дахин боловсруулах боломжтой ч одоогоор огт боловсруулалт хийдэггүй. Дөнгөж 3-5 хувийг нь л хоёрдогч түүхийг эд болгон экспортолж байгаа аж...30

### Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо

Бидний эргэн тойронд байгаа байгалийн бас нэгэн баялаг болсон агаар, хоосон зайг ашиглаж бизнес явуулж байна. Энэ агуулгаараа байгальд үнэхээрийн ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болно...36



## БИЗНЕС


- 10 Зайрмагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл
- 14 Ямаа ба кофе
- 16 Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан
- 18 Чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх нь компанийн хариуцлага юм
- 19 Сонгуулийн эдийн засаг
- 22 Монгол нүүрсний баялгаа “ногоон” нүүрс болгох боломжтой
- 24 Буцалж буй Ханбогд
- 24 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд
- 27 Салхины үнэрээс хуваалцахуй

## Эдийн засаг

- 30 Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл
- 33 Хүнд ажлын хямд хөлс
- 36 Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо
- 40 Давалгааг дага
- 42 Азийн хөгжлийн загвараас бидэнд сурах зүйл бий юү?

## МОНГОЛД

### Үнэ ханш



Шатахууны үнийг литр тутамд 50 төгрөгөөр нэмлээ. Шатахуун импортлогчдын төлөөлөл Монголбанкнаас бидэнд 83 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон учир 50 төгрөгөөр нэмж байна. Зээл олгоогүй бол литр тутамдаа 210 төгрөгөөр нэмэгдэх тооцоо байсан” хэмээн тайлбарлаж байгаа аж. Ингэснээр А-80 бензин литр тутам нь 1530, АИ-92 1620, дизель түлш 1750 төгрөгийн үнэтэй болжээ.

### Жижиг, дунд үйлдвэрлэл

Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн

албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөллөө. Уг салбарт хөдөлмөр, хүчээ зориулж буй олон мянган хүнд ашиг тусаа өгөх уг татварын чөлөөлөлт ирэх оны арванхоёрдугаар сарын 31-нийг хүртэл хүчинтэй.

### Дэд бүтэц

НЗДТГ-аас Гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн хэмжээнд дахин төлөвлөлт хийхээр 15 нэгж газрыг сонгожээ. Үүнээс эхний ээлжинд Баянзүрх, Сонгино хайрхан, Чингэлтэй, Баянгол дүүргийн нийт зургаан хэсгийн гэр хорооллыг сонгосон бөгөөд иргэдтэй зөвшилцсөний эцэст дахин төлөвлөлт хийх юм байна.



### Зээл

ҮХААЯ, Монголбанк хамтран “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд энэ сараас гурилын үйлдвэрүүдэд дөрвөн хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай 61 тэрбум төгрөгийн зээл олгохоор боллоо. Одоогийн байдлаар ҮХААЯ-нд 46 аж ахуйн нэгж зээл авах хүсэлтээ ирүүлж, 35 нь шалгараад байгаа. Зээлд хамрагдсан компаниуд агуулахдаа улаан буудайн нөөцтэй, сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа, санхүү, тайлан балансын хувьд алдагдалгүй, бүтээгдэхүүн нь чанартай байх шаардлагыг хангасан байх юм.

### Өөрчлөлтийг өөрөөсөө

Ногоон бол зөвхөн өнгө биш. Энэ бол шинэ зууны сэтгэлгээ. Эх дэлхийн иргэд ногоон хөгжилд тэмүүлэх болоод багагүй хугацааг үдээд буй. Улс төр, эдийн засаг гээд өргөн хүрээг хамрах болсон ногоон сэтгэлгээг

## "НОГООН ОФФИС" БИДНИЙ ГЭР

монголчууддаа ойлгуулах, улмаар дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорин Mongolian Economy сэтгүүлийн хамт олон “Ногоон хөгжлийн төлөө” уриан дор үйл ажиллагаагаа явуулдаг билээ.


Өөрчлөлтийг өөрөөсөө гэдэг. Эрүүл орчинд ажиллах нь эрч хүч, урам зориг өгөхөөс гадна ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нь гарцаагүй. Иймээс манай хамт олон ногоон хөгжлийг дэмжих ажлыг байгууллагаасаа эхэлж, “Ногоон оффис- Бидний гэр” уриа дэвшүүлэн ажиллаж эхэллээ.

Ногоон эдийн засгийг дэмжигч байгууллагынхаа хувьд сэтгүүлийнхээ редакцийг ногоон орчин болгон тохижуулахын зэрэгцээ цахилгаан, цаас хэмнэх, хог хаягдлыг ангилан ялгаж зэрэг олон оронд хэрэгжих болсон энгийн атлаа асар үр нөлөөтэй аргыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгохын сацуу олон нийт, байгууллагуудыг ч мөн ногоон хөгжлийн төлөө хөл нийлүүлэхийг уриалж байна. ➤

### Эдийн засаг

Монгол Улсын ДНБ 2013 онд 19 хувиар өсөж, 19 их наяд төгрөгт хүрч магадгүй гэж “Frontier Securities” компани таамагласан байна. Учир нь уул уурхайн томоохон ордууд бүрэн хүчин чадлаараа ажиллах нь эдийн засгийн өсөлтөд энэ мэт эерэгээр нөлөөлнө хэмээн шинжээчид үзэж буй. ОУВС, Дэлхийн банк Монголын эдийн засгийн өсөлтийг ирэх онд 13.8 хувь байна гэж үзэж байгаа бол олон улсын үнэлгээний “Fitch” агентлаг 14.1 байна хэмээн таамаглажээ.

### Монголын ДНБ-ий өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Eurasia Capital

▶ ОРОС

**Оросын** “Транснефть” компани Зүүн Сибирь-Номхон далайн /ESPO / хоёр дахь салбарын газрын тос дамжуулах хоолойн нээлтийг хийлээ. Ингэснээр /ESPO / газрын тос дэлхийд шинэ жишиг тогтоох боломжоо нэмэгдүүлж байгаа агаад Ази тивийн улс орнууд газрын тосны шинэ нийлүүлэлттэй болж байгаа юм. Балтын тэнгисээс Номхон далай хүртэлх энэ хүү хоолой ашиглалтад орсноор газрын тосны нийлүүлэлт жилд 30 сая тоннд хүрэх тооцоо байгаа. Харин нийт экспортын хэмжээ 2013 онд 36 сая тонн болно хэмээн тооцоолоод байна.



**TNK-BP** газрын тосны акулыг худалдаж авахаар гэрээлсэн “Роснефть” компани урьдчилгаа 50 тэрбум ам.долларыг “Vitol”, “Glencore” зэрэг томоохон байгууллагаар гаргуулж, 16.8 тэрбум ам.долларыг нь банкны зээлээр төлөхөөр шийдвэрлэж чаджээ. “Vitol”, “Glencore” компаниудтай байгуулсан гэрээний дагуу “Роснефть” компани 2013 оноос эхлэн таван жилийн турш 67 сая тонн түүхий нефтийн тээвэрлэлт хийж

өгөхөөр болсон байна. Гэрээний нэг хэсгийг бэлэн шатахуунаар орлуулж ч магадгүй юм. Үнийг тодорхой тусгаж өгөөгүй ч нэг баррель нь 100 ам.доллар гэж үзвэл 67 сая тонн газрын тос 500 тэрбум ам.доллартай тэнцэх билээ.

**ХЯТАД**

**Хятадын** газар нутгийн талыг бүрхсэн дэлхийн хамийн урт хурдан галт тэрэгний зам ашиглалтад орлоо. Нийт 2298 км үргэлжлэх тус төмөр замын сүлжээгээр хурдны галт тэрэг цагт 300 км цаг хурдлах боломжтой бөгөөд 20 цагийн аяллыг найман цаг болгон

багасгаж өгчээ. Бээжин-Гуанжоу хоорондын дээрх төмөр замыг оролцуулбал Хятад улс нийт 9300 км газар үргэлжлэх хурдны галт тэрэгний нэгдсэн сүлжээтэй болж байна.



**Хятадын** ерөнхийлөгч Ху Жин Тао Ардын Их Хурлын Байнгын хороотой хэлэлцсэний үндсэн дээр Хятад улсыг төлөөлүүлэн таван Элчин сайдыг шинээр гадаадад томиллоо. Тэдгээр улст Унгар, Мозамбик, Гайана, Кабо-Верде, Исланд орж байна. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН

**Дэлхий “сөнөсөн”-ий маргааш**



Шог зургийг А.Амарсайхан

ТОЙМ

# ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨДРӨГ ӨНГӨ

И.ОТГОНЖАРГАЛ

Өндөр өсөлт, өөдрөг байдлаараа дэлхийн анхаарлын төвд орсон Монголын эдийн засгийн хөгжлийг нь хурдасгах салбарын яамтай болов.



Монголын эдийн засаг хэмээх их айл удахгүй улиран одох гэж буй 2012 оныг ямархан ололт амжилт, алдаа дутагдлаар дүүрэн өнгөрөөж, айсуул шинэ оноо угтах гэж байна вэ гэдгийг дүгнэн цэгнэх торгон мөч айлслаа.

Европын холбооны орнуудын хямрал, БНХАУ-ын эдийн засгийн удаашрал гээд том гүрнүүдийн зах зээлийн таагүй байдал жижигэн

Монголын том өсөлттэй эдийн засгийг бараг бүтэн жилийн турш “аргамжлаа”. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд огцом өсөлтөөрөө дэлхийг алмайруулж буй Монголын эдийн засгийг энэ онд 14-15 хувийн өсөлттэй гарна гэсэн таамаг бий. Дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагынхан, шинжээчдийн урьдчилан харж буй дээрх таамагас хамгийн даруухныг нь энд тэмдэглэхэд Дэлхийн банк ямар ч тохиолдолд

Монголын эдийн засаг энэ онд 10 хувиас доошоо орохгүй гэж эрт мэдэгдсэн. Өнгөрсөн жил 17.5 хувийн өсөлт үзүүлж байсан манай эдийн засаг оны эхэнд 16.5 хувиар өсөж байсан ч эхний хагас жилийн байдлаар өсөлт саарч 13.2 хувь болсон билээ. Энд юу нөлөөлсөн бэ. Гадаад нөхцөл байдлаас гадна сонгуулийн өмнө 21 мянган төгрөгийг эцэслэх, өндөр настан, тахир дутуу иргэдэд хайр зарласан сая төгрөг гээд тавдугаар сард “мөнгөөр бороо” орсон. Энэ байдал нь зуны аагим халуунд цухалдсан олон түмнийг инфляци хэмээх хадны мангаагаар айлгаж улам бачууруулж байлаа. Ингэж их мөнгө тарааж байхад сонгуулийн дараа инфляци юу л болдог бол доо гэсэн болгоомжлол ч хэдийнэ хүмүүст төрсөн байсан. Харин аз болоход сонгууль угтсан бэлэн мөнгөний тараалт инфляцид төдийлэн нөлөөлөөгүй. Өөрөөр хэлбэл, эдийн засагчдын сонгуулийн үеэр тараагдаж байгаа их мөнгө хэдийнэ инфляцийн тооцоонд орчихсон байх талтай. Тийм болохоор инфляци одоогийн түвшингээсээ огцом харайгаад явчихгүй болов уу хэмээн таамаглж байсан нь талаар болоогүй гэсэн үг.

Гадаад зах зээлийн хүчин зүйлээс шалтгаалан өнгөрсөн есдүгээр сарыг дуустал манай экспортын орлогын гол цөм нь болсон уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан. Тухайлбал, сүүлийн жилүүдэд эдийн засгийг сөгийтөл өргөж гаргаж ирсэн нүүрсний экспортын эхний найман сарын төлөвлөгөө тасарч, 12 сая тонныг ▶

► экспортолсон байх жишээтэй. Гэхдээ энэ байдал удаан үргэлжлээгүй нь сайн хэрэг. Хятадын эдийн засаг өнгөрөгч аравдугаар сард гадаад худалдаа ашигтай гарч, аж үйлдвэрийн салбарт өсөлт ажиглагдсан зэрэг олон сайн мэдээ дуулгасан нь таатай байлаа. Мөн сард манай инфляцийн жилийн өсөлт 15 хувьтай гарсан нь өмнөх сарынхаас ялимгүй буурсан үзүүлэлт байсан юм. Үүнд инфляцид байнга лантуу мэт жин дардаг махны үнийн бууралт нөлөөлсөн гэж мэргэжлийн хүмүүс тодотгож байв. Түүнчлэн эрчимтэйгээр суларч байсан төгрөгийн ханш аравдугаар сарын дунд үеэс чангарах хандлагатай болсон. Үүнийг “Худалдаа хөгжил”-ийн банк олон улсын зах зээлд бонд арилжаалснаас улбаатай Монголын валютын нөөц түр зуур нэмэгдсэн гэж “Мандал даатгал” компанийн шинжээч, судлаачид тухайн сарын дэлхийн болон дотоодын зах зээлийн тоймдоо дурдсан байсан.

Саяхан манай Засгийн газар олон улсаас 1.5 тэрбум ам.долларын бонд босгож, бондын мөнгө энэ сарын 12-нд Монголын дансанд орж ирсэнээр манай валютын нөөц огцом өссөн дүнтэй байгаа нь онцлон тэмдэглэх зүйл. Бонд босгох үйл ажиллагаа ингээд зогсчихгүй дахин 3.5 тэрбум ам.доллар олохоор байгаа нь шинэчлэлийн Засгийн газрын санхүүжилтийн тал дээр том зорилт тавин ажиллаж буйг илтгэх. Харин бондын мөнгийг үр ашигтай төсөлд зарцуулах гэдэг нийгмийн анхаарлыг татсан халуун яриа болоод байна. Засгийн газрын зүгээс ч бондын мөнгийг юунд зарцуулах талаар салбар салбарын хүмүүсийн санаа бодлыг сонсож байгаа нь сайшаалтай хэрэг. Мөн Нээлттэй нийгэм форумаас олон улсын зах зээлээс босгосон Чингис бондын 1.5 тэрбум ам.долларын санхүүжилтийг юунд зарцуулах нь ашигтай вэ гэдэг асуудлаар “My budget facebook”-ээр санал асуулга явуулахад төмөр зам 349 санал, зэс хайлуулах үйлдвэр 341, аж үйлдвэрийн парк 1108, нефть боловсруулах үйлдвэр 4656, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахад 2582, Улаанбаатар хотод метро барихад 1892 санал тус тус ирсэн байна.

Шинэ Парламент ирэх оны нэгдсэн төсвийг 7.44 их наяд төгрөгт баталлаа.

Энэ нь ДНБ-ий 42.2 хувийг эзэлж, төсвийн алдагдлыг 2-5 хувьд барихаар төсөвлөсөн. Ерөнхийдөө бол өмнөх жилүүдийн данхайсан төсвөөс нэг их дээрдээгүй бөгөөд мэргэжлийн хүмүүсийн зүгээс “Төсөв-2013”-д дунд дүн тавьж буй. Төсвийн орлогыг хэт өөдрөг төсөвлөсөн, зарцуулалтыг хангалттай хэмжээнд багасгах талаар дорвитой анхаараагүй зэрэг нь ийн дүгнэхэд хүргэж буй. Гэхдээ 2013 оны төсөвт томоохон онцлог бий. Тэр нь батлагдаад бүтэн хоёр жил хүлээгдэж, ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлэх Төсвийн тогтвортой байдлын тухай хууль юм.

Дараагийн энэ онд Монголын эдийн засагт нэлээд анхаарал татаж байгаа нэг асуудал бол Монголбанкны дэвшүүлээд буй “Чинээлэг дундаж давхарга, нам инфляци” гэсэн зорилт юм. Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал “Орлогын түвшин,

моргэйжийн зээл, хуримтлал талаас нь авч үзэхэд Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийн зайлшгүй нөхцөл болох дундаж давхарга маш сул байна. Энэ нь эдийн засгийн эрсдэл (хөрөнгө төвлөрөх, хөрөнгө огцом гадагшлах)-ийг бий болгож байна. Нийгмийн халамжийн зардлаас үүсэлтэй инфляцийн дарамт олон жил дараалан өндөр байгаа нь эдийн засгийн өсөлт дундаж давхаргад мэдрэгдэхгүй байх, ядуурлын түвшин буурахгүй байх, эдгээрийн үр дагавраар эдийн засгийн эрсдэл улам нэмэгдэж байна” хэмээж буй. Тиймээс Төвбанк, Засгийн газартай хамтарч орлогын ялгааг үүсгээд буй гол нэрийн бүтээгдэхүүний үнийн зохицуулалтыг хийхээр хөтөлбөр боловсруулан ажиллаж байгаа билээ. Замын-Үүдээр орж ирэх хүнс, барилгын материалын нийлүүлэлтийн сувгийг сайжруулах, шатахуун импортлогч, гурил үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүний ►



Эх сурвалж. СЯ, 2012.09 сар

үнийг тогтвортой байлгах чиглэлд санхүүжилт олгох зэрэг бодитой ажлууд хийж байгаа ч жамаараа хөгжих зах зээлийн хөгжлийг гажуудуулж, буцаад төлөвлөгөөт эдийн засаг руу оруулах нь гэсэн багагүй шүүмжлэлтэй тулгарч байгаа билээ. Иргэд сүүлдээ аль нь зөв, аль нь бурууг мэдэхгүй эргэлзэхэд хүрч буй. Үнэндээ бол эдийн засагчдын тайлбарлаж буйгаар Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг өнөөдрийн нөхцөлд буюу богино хугацаанд байх ёстой зүйл. Харин урт хугацаанд энэ чиглэлээр хийх зүйлээ давхар авч явах хэрэгтэй гэдгийг хэлж байгаа юм. Тэгэхээр эндээс ямар нэгэн үр дүн харагдах нь гарцаагүй.

Эцэст нь хэлэхэд, Монголын эдийн засгийн өсөлт оны төгсгөлд

ямар ч гэсэн хоёр оронтой тоон үзүүлэлтээр илэрхийлэгдэж, дэлхийг гайхшруулсан өмнөх оны өндөр өсөлтөө хадгалах болов уу гэсэн мэргэжлийн хүмүүсийн таамгийг энд мөн тэмдэглэх нь зөв байх.

Харин хэдхэн хоногийн дараа гарах 2013 оны эдийн засгийн төлөв ямар байх бол гэдгийг товчхон тэмдэглэе.

Ирэх оны эдийн засгийн төлөвийг Оюутолгой төсөл өнгөлсөн хэвээр байх хандлага байна. Учир нь, Монголын эдийн засагт 6.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг авчирсан тус төсөл удтал яригдсан эрчим хүчний асуудлаа саяхан шийдэж, баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулж байгаа нь их ирээдүйг зөгнөх. Түүнчлэн

Оюутолгойн орд ашиглалтад орж, үйлдвэрлэлээ явуулсан нөхцөлд Монголын эдийн засгийн өсөлт 16 хувьтай байна гэсэн өөдрөг төсөөллийг Дэлхийн банк гаргасан байна. Ганц Оюутолгой гэлтгүй өнгөрч буй онд “амралтын байдалтай” нам жим байсан Таватолгойн ордын ажил ундраад ирвэл манай эдийн засагт бас нэгэн хөдөлгүүр нэмэгдэж, төсвийн алдагдал багасах, ДНБ өсөх зэрэг таатай мэдээнүүд цуврах нь дамжиггүй. Улаанбаатарын сүрлэг барилгуудын өмнөх айсуу оныг угтсан гоёмсог засал чимэглэл өмнөх жилүүдээс улам бүр өнгө жавхаа нэмж, шөнийн ододтой өнгө сүлэлдэхийг ажваас Монголын эдийн засаг өөдрөг өнгөлөг хэвээр байх ажгуу. ■

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ 2012 ОНД ДЭНДҮҮ БАЧИМДМААР БАЙЛАА

### Б.ЭНХЦЭЦЭГ

**Улс орнуудын нөхцөл байдлаас үүдэн таамаглал ташаарч дэлхийн, бүсийн төдийгүй олон орны эдийн засгийн таамаглалд сөрөг өөрчлөлт орсон билээ.**

Дэлхий дээрх үндэстэн хоорондын эдийн засаг, улс төр, хүн зоны уялдаа нарийсч, харилцан хамаарал нягтаршисан нь олон зуун жил хүн төрөлхтний төсөөлж ч зүрхлээгүй олон боломжийг нээж өгсөн ч түүнтэй тэнцэхүйц томоохон эрсдэлийг мөн авчирсан. Үүнийг 2008/2009 оны дэлхийн санхүүгийн хямрал гэрчилнэ. Юм нэгээр дуусдаггүй гэдэг. Тэгвэл өнгөрсөн санхүүгийн хямрал сүүлээ шарваж байна уу эсвэл галт луу хаалгаар орж ирэх гэж зүтгээд байна уу гэдэг одоохондоо тодорхой

биш. Гэсэн ч энэ жил олон улсын байгууллагууд бүгд л эдийн засгийн урьдчилсан таамаглалаа бууруулж, улс орны чадавхийг илэрхийлдэг зээлжих зэрэглэлийг буурууллаа. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хөгжингүй орнуудын эдийн засаг хэрхэн хямарч, ажилгүйдэл, дотоодын нийт бүтээгдэхүүн, экспорт, импорт, өр зээл, хувьцаа, таваар, валютын ханш тэргүүтэй эдийн засгийн гол үзүүлэлтүүд огцом биш ч аажимдаа буурч байгаа бараан мэдээг түлхүү дуулгасан.

### Таамаг таарсангүй

Энэ оны эхэнд олон улсын байгууллагууд дэндүү өөдрөг эдийн засгийн төсөөлөл гаргаснаа ухаарч жилийн эхний хагасаас тооцооллоо бууруулж, нэгээс хоёр өөрчлөлт хийсэн билээ. Улс орнуудын нөхцөл байдлаас үүдэн таамаглал ташаарч дэлхийн, бүсийн төдийгүй олон орны эдийн засгийн таамаглалд сөрөг өөрчлөлт орсон билээ. Тухайлбал, Дэлхийн банк дэлхийн эдийн засгийн 2012 оны өсөлтийн таамгаа бүтэн нэг хувиар бууруулж оны эхэнд 2.5 хувь болгосон бол ОУВС 4.1 хувийн төсөөллөө 3.3 хувь болтол огцом доошлуулсан билээ. Хэрэв евро бүсийн өрийн хямрал эрчимжвэл дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурд ▶▶



дөрвөн хувиар доошилж ч болохыг Дэлхийн банкны мэргэжилтнүүд сануулж байсан юм. Харин ОУВС-гийн мэргэжилтнүүд бодлого тодорхойлогчдын авч хэрэгжүүлж байгаа олон арга хэмжээг үл харгалзан дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд учирч болох эрсдэлүүд өнгөрсөн зургаан сард үлэмж хэмжээгээр өсөн нэмэгдсэн хэмээн тайлбарласан юм. Түүнчлэн Эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага /ЭЗХХАБ/ дэлхийн эдийн засгийн өсөлтийг 3.4 хувь байна хэмээн үзсэн. Дэлхийн банк бусад томоохон байгууллагын таамаглалтай харьцуулахад хамгийн гутранги эдийн засгийн төсөөлөлтэй байжээ.

Тэгвэл бүсийн хэмжээнд хөгжиж буй Зүүн Азийн эдийн засгийн өсөлтийг 2012 онд 7.6 хувь байна хэмээн оны эхэнд тооцоолж байсан Дэлхийн банк энэ аравдугаар сард дээрх таамаглалаа шинэчилж, 7.2 хувь болгон бууруулав. Энэ нь Ази Номхон далайн бүсийн хувьд 2001 оноос хойших хамгийн удаашралтай өсөлт болж байгаагийн зэрэгцээ 2009 оны санхүүгийн хямралын оргил үеийнхээс ч доогуур үзүүлэлт.

Харин АХБ өнгөрсөн дөрөвдүгээр сард Азийн нийт 45 улсын эдийн засгийн нийлбэр өсөлтийг 2012 онд 6.9 хувь байна хэмээн харж байсан ч аравдугаар сард дээрх таамагаа бууруулж 6.1 хувь болгосон. Тус банкны мэргэжилтнүүд Дэлхийн эдийн засаг энэ жилийн эхний хагаст таамаглаж байснаас илүү бууралттай байлаа. Тэгвэл өнөөгийн дэлхий нийтийн эдийн засгийн бууралт нь түр зуурын шинжтэй буюу 2008, 2009 оны хямралыг аажмаар даван туулж буй бартаат замын нэг үү эсвэл удаан үргэлжлэх шинэ хямралын эхлэл үү гэдэг чухал асуулт гарч ирж байгааг онцолсон. Дэлхийн банк өмнөх онд хөгжиж буй улсууд 6.2 хувь, орлого өндөртэй орнууд 2.7 хувийн тус тус эдийн засгийн өсөлтийг үзүүлнэ хэмээн таамаглаж байсан ч энэ жилийн нэгдүгээр сард 5.4 болон 1.4 хувь болгон ойролцоогоор нэг хувиар буулгасан билээ. Дэлхийн банкны мэргэжилтнүүд Бразиль, Энэтхэгийн эдийн засгийн тэлэлт агшиж, Орос улс үл мэдэг өсөлт үзүүлэн Африк, Турк тэргүүтэй улсын эдийн засаг удаашраад эхэлчихсэн учир хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт тэр чинээгээр саарахаар байна

хэмээн үзсэн. Дэлхийн эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэгч орнуудын эдийн засаг хямарснаас үүдсэн удаашралын давалгааг хөгжиж буй орнууд давж чадах эсэх нь тухайн улс орны төдийгүй тодорхой гүрнүүдийн хүчин чармайлтаас шалтгаална. Тэргүүлэгч орнуудын ДНБ-ий өсөлт энэ онд 1.1 хувь байна хэмээн Азийн хөгжлийн банк тайландаа тусгажээ. Цаашдын дэлхийн эдийн засгийн хувь заяа Европ болон АНУ-ын бодлого тодорхойлогчид тэдэнд тулгарч буй эдийн засаг, улс төрийн сорилтуудыг даван туулахад ухаалаг хандаж чадах эсэхээс ихээхэн хамаарна гэдгийг тус банкны мэргэжилтнүүд дүгнэн хэлж буй. Харин ЭЗХХАБ-аас Америкийн төсвийн ангал томорч, евро бүсийн хямрал жилийн эцсээр гүнзгийрч байгаа нь дэлхий нийтийн үйлдвэрлэлийн салбарт үр ашиг бууран, эдийн засгийн удааширч тодорхойгүй байдал бий болоход голчлон нөлөөлсөн хэмээн оны эцэст мэдэгдсэн билээ. Ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг евро бүсийн өрийн хямрал хоёр хувиар, Америкийн төсвийн ангал нэг хувиар доош нь татна гэсэн тооцооллыг Дэлхийн банкнаас гаргаад байна. ▶

## ► Америкийн нэгдсэн улс

Америкийн энэ жилийн ДНБ-ий өсөлтийг 2.3 хувь байна хэмээн ЭЗХАХБ таамаглаж байсан ч саяхан хоёр хувь болгон өөрчилсөн бол АХБ 1.9 хувь дээр тогтоно гэж үзэж байна. Дэлхийн банкны мэргэжилтнүүд Америкийн 2012 оны өсөлтийг хоёр хувиас доош байна хэмээн харж байгаа. Харин Олон улсын валютын сан эсрэгээрээ хоёр хувиас дээш буюу тодруулбал 2.2 хувь байна хэмээн шинжлээд байна. Санхүүгийн хавчигдмал орчин, танасан төсөв зэрэг нь өсөлтийн замд хөндөлсөж байгаа хэмээн шинжээчид үзэж байгаа. Өнгөрсөн хямралаас хойш АНУ дараагийн хямралаас сэргийлэн олон төрлийн сангийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Мөнгөний тэлэх бодлогоор эдийн засгаа дэмжиж

ирсэн нь өрийн дарамтыг бий болгож эхэлсэн ч Барак Обама конгрессын гишүүдтэй цаашдын төсвийн бодлогоо хэлэлцэж байна. Тус улсын ДНБ-ий дөрвөн хувьтай тэнцэх төсөл хөтөлбөрүүд ирэх оны эхэн гэхэд дуусгавар болно. Гэвч энэ жил АНУ-ын ажилгүйдэл 7.7 хувьд хүрсэн нь сүүлийн дөрвөн жилд байгаагүй нааштай үзүүлэлт байлаа. Өнгөрсөн сарын есдүгээр сард тус улсын Нөөцийн банк ажилгүйдлийн түвшин 6.5 хувь хүртэл мөнгөний бодлогоо чангатгахгүй гэсэн мэдэгдэл хийсэн байгаа. Түүнчлэн эдийн засгийг доош татаж буй хөдөлмөр эрхлэлт, өсөлтийн удаашралаас эдийн засгаасаа хол байлгах үүднээс ажилгүйдлийн түвшинг мөнгөний бодлоготой уяхын зэрэгцээ энэ



жил дахин их хэмжээний мөнгөн дэвсгэрт хэвлэж гаргахаар болсноо тус банк зарласан билээ. Өнгөрсөн арваннэгдүгээр сард болсон ерөнхийлөгчийн сонгуулиар Барак Обама улиран сонгогдож дараагийн дөрвөн жилд АНУ-ын хувь заяаг дахин гартаа атгах боллоо.

## Евро бүс

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамгийг уруудуулсан гол татах хүч нь евро бүсийн өрийн хямрал байсан гэдгийг олон улсын шинжээчид хэлж байгаа. Бүсийн хямралд Өмнөд Европын орнууд голлох нөлөөг үзүүлж байгаа. Түүнчлэн зээлийн эх үүсвэр тэгийг зааж хүчтэй зогсолт хийн төсвөө их хэмжээгээр танамагц бүсчилсэн эдийн засгийн хувьд нэг нэгнийгээ чирэх үйл явц эхэлсэн. ОУВС евро бүсийн хямрал толгой өвтгөсөн асуудал хэвээр байгааг өнгөрч буй оны турш анхааруулж байв. Бүсийн тэргүүлэгчдийн зүгээс

авч хэрэгжүүлж байгаа урт ба богино хугацааны арга хэмжээний үр дүн 2012 оны эдийн засагт тусгалаа олохгүй ч 2013 онд магадгүй нөлөөлөл нь гарна хэмээн мэргэжилтнүүд үзэж байгаа. Евро бүсийн сангийн сайд нар 500 тэрбум еврогийн сантай Европын тогтворжуулах механизмыг есдүгээр сард танилцуулж, 100 тэрбум еврогоор Испанийн банкуудад зузаатгал хийсэн. ОУВС-гаас энэ оны эхэнд бүсийн өсөлтийг жилийн турш 0.3 хувь байна хэмээн таамагласан ч үүнээс гурван сарын дараа 0.4 хувь болгож ялимгүй өсгөсөн бол АХБ энэ



аравдугаар сард 0.6 хувь байна гэж тооцсон.

## БНХАУ

АНУ-ын эдийн засгийн удаашрал, Европын өрийн хямрал Хятадыг багагүй шахалтад оруулж, дотоодын сул эрэлт, хөрөнгө оруулалтын агшсан үзүүлэлттэй хүчтэй тэмцэхэд хүргэсэн. Тэгвэл АХБ энэ жил Хятад улсын өсөлтийг 8.5 хувь байна хэмээж байсан ч оны сүүлийн тайландаа 7.7 хувь болгон бууруулсан. Харин

Дэлхийн банкны зүгээс ДНБ-ийг нь 8.2 хувийн өсөлттэй гарна гэсэн ч оны эцэст 7.7 болголоо. Үүнтэй зэрэгцэн ОУВС оны эхэн дэх Хятадын өсөлтийн таамгаа хагас хувиар буулгаж 7.8 хувь болгосон юм. Харин Швейцарын банкны салбарын акул UBS Хятадын өсөлтийн таамгаа 0.5 хувиар бууруулж 7.5 хувь болгосон ►►



► бол “Голдман Саакс” 7.6 хувь болгож өөрчилсөн байгаа. Азийн төдийгүй дэлхийн эдийн засгийн тулгуур Хятад улсын бараа бүтээгдэхүүний голлох зах зээл евро бүс, АНУ тэргүүтэй бүс нутгийн эрэлт багассан нь голлох нөлөөг үзүүлсэн бол Зүүн Азийн орнуудын эдийн засгийн нөхцөл

байдал, тус улсын дотоод хүчин зүйлс удаашралд тодорхой хувийг нэмэрлэжээ. Хятад улсын энэ оны онцлох үйл явдлаар тус улсын арван жилд нэг удаа тохиодог засаглалын цус сэлбэлт байсан билээ. Энэ жилийн арваннэгдүгээр сард ХКН-ын Төв хорооны Бүгд хурлаар хийж,

Коммунист намын удирдагч Ху Жин Таогийн орыг Си Жинпин ирэх оноос залгахаар болсон билээ. Түүнчлэн ирэх арван жилд Лууг захирах төрийн өндөрлөгүүд тодорч Ли Кэцян тэргүүтэй таван шинэ гишүүн Намын Их Хурлын тэргүүлэгчдээр сонгогдсон том үйл явдал болсон билээ.

## Япон

Дэлхийн нийтийн анхаарлыг татсан энэ жилийн томоохон үйл явдалд тус улс болон Хятадын хоорондох Сэнкаку арлыг өмчлөх маргаан байсан билээ. Япон улсын экспортыг нуруундаа үүрч явдаг Хятад улсын иргэд энэ жил тус улсыг эсэргүүцэн бараа бүтээгдэхүүнийг нь авахаа больсноос үүдэн экспортын салбарт их хэмжээний алдагдал хүлээхэд хүрсэн. Японы ДНБ жилийн эхэн үетэй харьцуулахад 3.5 хувиар багассан бол эдийн засаг нь өмнөх гурван сартай харьцуулсан үзүүлэлтээр 0.9 хувийн агшилттай гарчээ. Голлох хүчин зүйлээр дэлхийн эдийн засгийн удаашрал, Хятад дахь

Японы эсрэг бослого хөдөлгөөн түүнчлэн тус улсын дотоодын хэрэглээ хавсарга байдлаар эдийн засагтаа өгөөж өгөх төдий байсан зэрэг байв. Өнгөрсөн оны газар хөдлөлтөөс хойш төсвийн зардал, сэргээн босголтын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор Японы эдийн засгийн сэргэлт 2012 онд эрчээ авсан. Хэдийгээр дэлхийн санхүүгийн хямрал эхэлсэнээс хойш үндсэн хэрэглээний ханш сар бүр буурсаар байсан ч 2011 оны дунд үетэй харьцуулахад үнийн уналтын хурд саарсан. АХБ-наас Японы эдийн засгийн өсөлтийг энэ онд 2.3 хувь байна хэмээн таамгаа эцэслээд



байгаа юм. Харин Дэлхийн банкнаас 2.6 хувийн өсөлтийн таамгаа 1.9 хувь болгон энэ оны эхэнд бууруулсан бол ОУВС долдугаар сард 2.4 хувийн өсөлт үзүүлнэ гэж байсан ч мөн л 2.2 болгон саяхан доош татсан юм.

## Энэтхэг

Азийн эдийн засгийн голлох тоглогчдын нэг Энэтхэг улсын эдийн засгийн төсөөлөл жилийн эхэнд шинжээчдийн зүгээс өндөр гарч байсан ч оны эцсээр мөн л буурлаа. АХБ зургаан хувийн өсөлтийн таамаглалаа 5.6 хувь болгон өөрчилсөн билээ. Тэдний зүгээс энэ жилийн Энэтхэгийн эдийн засгийн бууралтыг дэлхийн глобал эрэлт ба тус улсын борооны улирал хойшилж хөдөө аж ахуйн салбарт нийлүүлтийн гацаа үүссэнтэй холбон тайлбарлаж байна. Харин ОУВС-ийн мэргэжилтнүүд тус улсын өсөлтийг энэ долдугаар сард 6.2 хувь байна хэмээн хэлж байсан ч дөрөвдүгээр

улирлын эхэнд огцом бууруулж 4.9 хувь болгосон нь чангахан цохилт болсон юм. Азийн бусад оронтой харьцуулахад инфляци мэдэгдэхүйц өсөж, үнийн дарамт үүсгэсэн мөн бизнесийн орчин суларсан, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш үнэгүйдэж эхэлсэн, төсвийн алдагдал ихэсч буйг тус байгууллагын зүгээс тооцооллоо бууруулах голлох шалтгаан гэж тайлбарласан. Энэтхэг улс энэ оны эхний хагаст 5.3 хувь, хоёрдугаар хагаст 5.5 хувийн өсөлттэй байсан юм. Томоохон банк санхүүгийн байгууллагууд тухайлбал, Морган Стэнли 5.8, Сити 5.4, S&P 5.5 хувийн эдийн засгийн өсөлтийг зөгнөөд



байгаа ч тус улсын Засгийн газрын хувьд оны эцэст ч тэр эдийн засгийн өсөлтөө 6.5-6.7 хувь байна гэдэг тооцоолол дээрээ бат зогсоор байна. ■

“Mongolian Economy” сэтгүүл улиран одож буй 2012 онд Монголын улс төр, эдийн засаг, санхүү, бизнесийн салбарт өрнөсөн олон үйл явдлаас арван үйл явдлыг онцолж байна.

## 1 ШИНЭ СОНГОЛТ



2012 он. Хууль тогтоох төрийн дээд байгууллага УИХ-ыг бүрдүүлэх парламентийн болон орон нутгийн сонгуулиар амьсгалсан улстөрийн “дажинтай” жил байв. Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдаад 20 жил өнгөрч, ардчилсан засаглал тогтоод 22 дахь жилийн босгыг давах гэж байна. Монголчууд энэ онд зургаа дахь удаагийн УИХ-ын сонгуульдаа оролцож, сонголтоо хийлээ. УИХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн 48 нь мажоритори системээр 26 тойрогт “уралдсан” бол үлдсэн

28 нь намын нэрийн жагсаалтаар ялалт байгуулсан юм. Түүнчлэн гуравдагч хүчний орон зай улс төрд товойж гарсан онцлог жил байв.

Шинэ УИХ-ыг бүрдүүлэх зургаа дахь удаагийн парламентийн сонгуульд Ардчилсан нам ард түмний 35 хувийг саналыг авч, Засгийн газраа эвсэж байгуулах түүхэн “эрхийн бичиг”-ээ гардлаа. “Олуулаа ялна шүү” гэсэн уриа бүхий Ардчилсан нам хот, хөдөөд олуулаа ялсан ч засгаа дангаар байгуулах 39 хувийн суудлаас мултарч, аз дутсан. Гэсэн ч МАХН-МҮДН-ын “Шударга ёс” эвсэл, ИЗНН-тай хамтарч шинэчлэлийн Засгийн газрыг байгуулсан. Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайдаар АН-ын дарга Н.Алтанхуяг сонгогдож, “Шинэчлэлийн” гэх тодотголтой Засгийн газрын танхим бүрдэв. Энэ удаагийн хамтарсан Засгийн газар 16 яам, 19 сайд, 28 агентлагтай үйл ажиллагаа явуулж байгаа нь олон нийтийн зүгээс хэт данхар бүтэцтэй гэж шүүмжлэхэд хүргэсэн. Засгийн газрын шинэ танхимаас Ц.Оюунгэрэл, С.Оюун, Н.Удвал гэсэн гурван бүсгүй сайд болсон нь жендерийн харьцааг улс төрийн түвшинд ойртуулсан алхам болов. Мөн УИХ-ын 76 гишүүний 10 нь эмэгтэй улстөрч байгаа нь өмнөх үеийн таван Парламентаас эрс ялгаатай.

## 2 БОНДЫГ БООЛЧИЛЪЁ



Монголын Засгийн газар энэ жил сайн, муу олон шийдвэрээр дэлхийн зах зээлийг доргиооод авсан. Тэгвэл энэ оны дэлхийн болоод дотоодын эдийн засагт хамгийн их дуулиан тарьсан оны онцлох үйл явдлаар

Монгол Улсын Засгийн газрын их өрийн анхны бичиг яах аргагүй орно. Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан тэргүүтэй ажлын хэсэг өнгөрсөн арваннэгдүгээр сарын 28-нд Чингисээр овоглосон бондыг дэлхийн зах зээлд амжилттай арилжаалсан билээ. Чингис бонд Хонконг, Сингапур, Англи, Япон, Герман Америк зэрэг улсаар аялсны үндсэнд нийт 15.000 тэрбум ам.доллартай тэнцэх захиалга авсан. Таван жилийн хугацаатай 500 сая ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэй гаргасан бол арван жилийн хугацаатай нэг тэрбум ам.долларын бондоо 5.125 хүүтэй арилжааллаа. Энэхүү 1.5 тэрбум ам.долларыг нийт 605 сая ам.долларын хүүтэй хамт буцаан барагдуулна. Эхний 1.5 тэрбум ам.долларын зарцуулалт ДНБ-ий өсөлтийг дэмжиж, дотоодын эдийн засагт шингэж чадах эсэхээс үлдсэн 3.5 тэрбум ам.долларын бондын хувь заяа шийдэгдэнэ гэж үзэж байгаа. Монгол Улсын түүхэнд анх удаа тэрбум доллараар хэмжигдэх их өр ба том санхүүжилт орж ирлээ. Монголын бонд босгох ▶▶

► ажиллагаа дуусаагүй, ирэх жилүүдэд бондын хэмжээг таван тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлнэ. Түүнчлэн Чингис бонд гараад удалгүй “Finance Asia” сэтгүүлээс олгодог “Засгийн газрын шилдэг бонд-2012” шагналыг хүртлээ.

Бондын ашиглалт, зарцуулалтын туршлага нимгэнтэй

монголчуудын хувьд дэлхийд цуурайтсан Чингис бонддоо боолчлогдох, боолчлохын аль нь болохыг одоогоор хэн ч хэлж таашгүй. Ямартай ч түүхэнд байгаагүй том санхүүжилт түүнийг дагасан их эрсдэл Монголын сан хөмрөгт ороод ирсэн. Харин одоо саалиа хураах л үлдлээ.

## УГТАХ БЭЛЭГ

3

Зөвхөн 2012 оны хувьд ч бус Монголын түүхэнд онцлохоор нэгэн чухал зүйлийг монголчууд энэ онд бүтээжээ. Тэр нь “Transparency International” байгууллагаас жил бүр гаргадаг авлига, хээл хахуулийн судалгаагаар Монгол Улс өмнөх оноос 26 байраар урагшилж, 174 орноос 94 дүгээрт жагссан явдал байлаа. Үүнийг “Дэлхийн түүхэнд авлигын хэмжээ хамгийн хурдтай буурсан үзүүлэлтийг монголчууд анх удаа харууллаа” хэмээн зарлаж байна. Хэдийгээр дотоодод авлига хэрээс хэтэрлээ хэмээн шүүмжилж буй ч олон улсын байгууллагын түвшинд ийнхүү үнэлэгдсэн нь амьдралын чанар дээшлэх таатай мэдээ юм. Алигатай тэмцэх газраас Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг баривчилж, УИХ-ын сонгуульд нэр дэвшиж байсан “Сод Монгол” группын ерөнхийлөгч Ц.Анандбазар, Ашигт малтмалын газрын дарга асан Д.Батхуяг нарыг байцаан шалгаж, нэр дэвших эрхийг нь түдгэлзүүлэх байдлаар авлигатай ширүүн шийдэмгий тэмцсэн нь ийнхүү олон улсын тавцангаас



өндөр үнэлгээ авахад гол нөлөө үзүүлсэн биз ээ. Луу жилийн төгсгөлд гарсан авлигатай холбоотой сайн мэдээ ирэх жил иргэдийн амьдралд тод мэдрэгдээсэй. Хөгжил цэцэглэлтийн тушаа болсон авлигын хэрэн сүлжилдсэн гинжин урвал задран мөхөхийн эхлэлийг айсуу шинэ онтой зэрэгцэн угтаж байгаа гэж бэлгэшээе.

## САЙХАН ЗОРИЛТ

4

Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан томоохон ажлын нэг нь ганц тулгууртай эдийн засгаас олон тулгуурт эдийн засгийн тогтолцоонд шилжих. Харин олон тулгуурт эдийн засагт шилжихийн тулд аж үйлдвэрийн салбараа дэмжих том зорилт бий. Эл зорилтын үүднээс Засгийн газрын бүтцэд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам гэж тусгайлан гаргасан. Тус салбарын сайд Х.Баттулга ч дээрх зорилгын талаар өгүүлэхдээ “Энэ дөрвөн жилд Монголдоо тарьж ургуулж, үйлдвэрлэх боломжтой бүхнийг дотооддоо үйлдвэрлэнэ. Улмаар цааш цаашдаа Монгол Улс импортыг орлох бүтээгдэхүүнээр дотооддоо төдийгүй гаднын зах зээлд өрсөлдөх боломжийг эрэлхийлэх эхлэл өнөөдөр тавигдаж байгаа хэрэг юм” хэмээн өгүүлсэн биз ээ. Тус яамнаас “Үйлдвэржилтийн шинэ эрин үе” чуулганыг ч зохион байгуулаад амжсан. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, Улаанбаатар, Дархан-Уул, Эрдэнэт, Багануур зэрэг хот сууринд үйлдвэр, технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө буй нь сайхан зорилт билээ.



Мон Монголын газар тариалангийн салбар “Атрын III аян”-аар хөл дээрээ дахин боссон. Энэ онд л гэхэд дотоодын хэрэгцээнээс бараг хоёр дахин өндөр ургац авсан тул 100 мянган тонн улаа буудай урд хөршид экспортлох асуудал яригдсан. Төмсний хэрэгцээгээ хэдэн жилийн өмнөөс дотоодын ургацаар бүрэн хангадаг болсон бол өдгөө хүнсний ногоогоо ч хангах хэмжээнд очоод буй. Энэ бол дэвшил юм.

## 5 ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ СИСТЕМТЭЙ МОНГОЛ



Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг шинэчлэх үүднээс манай Засгийн газар Лондоны хөрөнгийн биржтэй 14 сая ам.долларын “Мастер гэрээ” үзэглэж, өнгөрсөн долдугаар сараас Монголын хөрөнгийн бирж Т+3 системийн дагуу арилжаа явуулж эхэлсэн билээ. Гурван жилийн хугацаанд хэрэгжих, дэлхийн 25 орны 30 орчим томоохон бирж, арилжааны төвд ашигладаг “Millennium IT” програмыг Монголын биржид нэвтрүүлсэн юм.

Шинэ систем нэвтрээд зургаан сар орчим болох гэж байгаа ч онцын үр дүн өгөхгүй байгаа талаар мэргэжлийн хүмүүс шүүмжилсээр буй. Улмаар шинэ системд Монголын брокер, дилерийн компаниуд “идээшиж” өгөхгүй, үнэт цаасны арилжаа нэлээд хумигдаж, мөн арилжаанд оролцохдоо төлбөрийн баталгааны санд 10 саяас дээш төгрөг байршуулсан байх болон шимтгэл нэмэгдсэнтэй холбоотойгоор 70 гаруй компанийг “ажил хаяхад” хүргээд авсан. Гэвч үүнийг мэргэжлийн хүмүүс “Шинэ систем нэвтэрсэнтэй холбоотойгоор нэлээд хатуу, чанга шаардлага тавьж байгаа нь компаниудад хүндхэн даваа болоод байна. Гэхдээ энэ байдал удаан үргэжлэхгүй” хэмээж буй юм. Манай хөрөнгийн зах зээл одоогоор олигтой сэхэл аваагүй байгаа ч Монголын түүхэнд дэлхийн хэмжээний систем нэвтэрсэн нь онцлох үйл явдал мөн юм.

## 6 БАНКНЫ БАТАЛГААЖСАН ЭРХ ЗҮЙ



Монголын санхүүгийн зах зээлийн 95 хувийг дангаараа эзэлдэг банкны салбар энэ онд тогтворжиж, хууль эрх зүйн орчин нь илүү боловсронгуй болсон гэдгийг эдийн засагчид онцолж байна. Тухайлбал, удтал яригдсан Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийг УИХ-аар баталсан. Тус санд иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн түүхийг нэгтгэсэн байх аж. Ингэснээр хувь хүн, албан байгууллагын хэр сайн зээлдэгч болохыг мэдээллийн сангаас хараад тодорхойлох боломжтой. Мөн давхардуулан зээл авах боломжийг хааж, зээлдэгчдийн сахилга батыг дээшлүүлж буй маш чухал хууль гэдгийг Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэн онцолсон. Банкны салбарын

энэ оны дараагийн томоохон өөрчлөлт нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хадгаламжийн хүүгээс татвар авахаар тусгасан явдал. Ингэснээр банкинд 100 сая төгрөгөөс дээш хадгаламжийг 12 сар хүртэлх хугацаатай байршуулсан тохиолдолд хадгаламжийн хүүгээс татвар авахаар болсон. Монголчуудын нийт хадгаламжийн хэмжээ 4.6 их наяд төгрөг, үүний 97 хувь нь цөөн хэдхэн хүний хадгаламж байдаг аж. Тийм ч учраас баячуудаас татвар авах хэрэгтэй гэж Засгийн газар өргөн мэдүүлсэн хуулийн төслөө хамгаалж байсан. Харин “Тэнгэр санхүүгийн нэгдэл”-ийн захирал М.Болд “Энэ хууль бодит байдал дээр хэрэгжихгүй. Учир нь, тухайн иргэн хөрөнгөө 100, 100 саяар нь хувааж 14 банкиндаа 13 сарын хугацаатай байршуулах маягаар зугтах гарцыг хайна” гэв. Ингэхлээр тус хуулийн “ид шид” гарахгүй ч байж болох нигууртай. Мөн УИХ-аар Хадгаламжийн даатгалын тухай хуулийг ид хэлэлцэж буй юм. Энэ хууль батлагдвал банкууд 20 хүртэлх сая төгрөгийн эрсдэлийг өөрсдөө дааж, даатгалд хамруулах юм. Ингэснээр манай банкны салбарын нийт хадгаламжийн 99 хувь, мөнгөн дүнгийн 38 орчим хувийг хамарч буй аж. Хуулийн хүрээнд Хадгаламжийн даатгалын сан байгуулна. Сангийн хөрөнгийг эхний ээлжинд Монголбанк болон Сангийн яамнаас тус бүр 50 тэрбум төгрөг гарган бүрдүүлэх аж. Мөн банкуудаас жил бүр нийт даатгуулсан мөнгөнийх нь 0.5 хувийг шимтгэл хэлбэрээр авах юм байна. ▶

## МОНГОЛЫН “НОГООН” ДУУ ХООЛОЙ

7

► Монголд амьсгал давчдуулсан бүгчим, цөлийн халуун агаар мэт уур амьсгалын өөрчлөлтийн салхи үлээж эхэлснээс хойш нэлээд хэдэн жилийн нүүр үзэж байна. Дэлхий дахин шинэ хандлага болох ногоон хөгжил рүү улам бүр хүчтэй орж буй энэ цаг мөчид Монгол Улс ч ногоон хөгжлийн бодлоготой болж байгаа нь энэ оны онцлох үйл явдал юм. Шинэчлэлийн Засгийн газар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам байгуулж, бас болоогүй тус яамыг ерөнхий чиг үүргийн дөрвөн яамны нэг гэж тодотгосон нь Монгол Улс ногоон хөгжилд тусгайлан анхаарч буйн илрэл. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам нь дотроо Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газартай бөгөөд тус газрын даргаар тогтвортой хөгжил, ногоон ирээдүйн талаар сүүлийн арав гаруй жил олон улсад Монголын дуу хоолой болж ирсэн профессор, доктор Т.Чулуун ажиллаж буйгаас үзэхэд “ногоон”-ыг зөвхөн ярих биш, үйл хэрэг болгохын үндэс болж байна гэж ойлгож болох.

Мөн өнгөрсөн зургадугаар сард Бразилийн Рио де Жанейро хотод болсон “Рио+20” дээд хэмжээний уулзалтад Т.Чулуун өөрийн санаачилсан “Улсуудын тогтвортой хөгжлийн индекс”-ийг танилцуулж, дэлхийд тулгамдаж буй байгаль орчны арван асуудлыг



тодорхойлоход Монголоос дуу хоолойгоо хүргэсэн нь манай улсын хувьд аз завшаантай үйл явдал болсон нь дамжиггүй. Түүнчлэн өнгөрсөн сард Катар улсын Доха хотод хуралдсан Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын бага хуралд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун үг хэлж дэлхийн “томчуудын” анхаарлыг татсан. Тэрбээр “Байгаль орчныг ихээр бохирдуулж байгаа орнуудын зүгээс олон улсын хэмжээнд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой арга хэмжээ авч, хөгжиж байгаа орнуудад техник технологи, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизм бүрдүүлэх талаар шийдвэртэй алхам хийх шаардлагатай байна” хэмээн Монголын дуу хоолойг хүчтэй илэрхийлэв.

## ХӨСӨР ХЭВТСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ДЭЭДЛЭВ

8

Төр, хууль хяналтын байгууллагуудын хийж, гүйцэтгэж чадахаа байсан шударга журмыг өнгөрч буй оны сүүлчээр ШӨХТГ нийгэмд цогцлоохыг хичээн зүтгэсэн нь ард түмний талархлыг ихэд хүлээв. Талархсан олон сүүлдээ болохгүй, бүтэхгүй бүхнээ “ШӨХТГ-ын Магнайд хаяглана шүү” гэцгээх болсон нь анзаарагдах болж. Аргагүй ээ, олон жил хөсөр хэвтсэн хэрэглэгчийн эрхийг анх удаагаа О.Магнай дээдэлсэн болохоор тэр. Монголдоо монополий эрх тогтоож, ямар ч эрхтэн дархтан, албан тушаалтан тэдний талаар муу үг цухуйлгахаа болиод удсан томоохон компаниудын асуудлыг ил болгож, “Мобиком”, “Скайтел”, “Ж-Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны компаниудтай ярианы тарифыг секундээр тооцохоор тохиролцсон, нефть импортлогчдийг шатахууны үнэ нэмбэл торгож, эрхийг нь түдгэлзүүлэхэд хүрнэ хэмээн “барьж”, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хуурай сүүгээр “жинхэнэ” сүү үйлдвэрлэлээ хэмээх бус “Сэргээсэн сүү” гэх шошготойгоор худалдаанд гаргах, сургалтын төлбөрөө үндэслэлгүйгээр нэмсэн их, дээд



сургуулиудад 25 сая төгрөгийн торгууль ногдуулсан, хар талх, чацарганын жүүс үйлдвэрлэгчдийг шалгаж, хэрэглэгчдийн эргэлзээг арилгасан зэрэг нийтэд тустай цөөнгүй ажлыг тус байгууллагын даргаар томилогдсон О.Магнай богино хугацаанд хийсэн. Бизнесийн шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг чухалчлах үүргээ биелүүлж, дайчин ажилласан түүний ажлыг бодлогоор дэмжиж, хууль бус зүйлсийг “номхруулна” гэж найдсаны дүнд Улсын ерөнхий байцаагчийн эрх хүртэл олгоод байгаа юм. Ирэх он бол ШӨХТГ-ын шударга бус бүхнийг илчлэх, засах жил болно хэмээн итгэх хүн олон байна. Тиймээс уг байгууллагыг ард түмний эрх ашгийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн онцолж байна. ►

## 9 ТОЛИГОР ЗАМ БА САЙН ШИЙДВЭР



► Улаанбаатарын жолооч нар өглөө, оройд замын түгжрэлд гэлдэрч, бухимддаг хэвээрээ. Гэхдээ тэдний бухимдал энэ онд бас ч гэж багассан. Магадгүй шинэхэн ашиглалтад орсон “Нарны гүүр” мэтийн замаар давхихдаа засмал замын сайхныг мэдэрч мушилздаг болоо биз. Хэдийгээр иргэд “Гурав хонохгүй ховхорч, жил болохгүй

цоордог” хэмээн чанарыг нь шүүмжилдэг ч хэдэн жилийн өмнөхийг бодвол Улаанбаатар хотод зам засварын ажлыг өнгөрсөн зун маш сайн хийж, нийслэлчүүд “толь шиг” замаар сүнгэнүүлж байгаа нь худлаа биш юм. Түгжрэлтэй ч гэсэн энхэл донхолгүй засмал замын сайхныг яана. Энэ онд “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд 76.2 км замыг шинэчлэн засварлаж, 21.5 км зам шинээр барьсан ба үүнд 67 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Мөн Улаанбаатар хотын шинэхэн Захирагч Э.Бат-Үүлийн тушаалаар нийслэлийн замын ачааллыг бууруулах зорилгоор авто машиныг улсын дугаарын сүүлчийн орноор нь хөдөлгөөнд оролцуулах, нийтийн тээврийн автобусыг зөвхөн нэгдүгээр эгнээгээр зорчихоор зохицуулсан нь өнгөрч буй онд төр, засгийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн хамгийн үр дүнтэй зөв шийдвэр байв.

## 10 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЯЛГИЙН ҮҮЦИЙГ ЗАДАЛЛАА



Оюутолгой ордын Хөрөнгө оруулалтын гэрээ бүрэн эрхээ баталгаажуулаад 38 сарыг үдэж байна. Монголчууд 1140 хоногийн турш Оюутолгой төслөөр “амьдарч”, бүтээн байгуулалтын “оргил цаг”-тай хөл нийлүүлэх түүхэн үе зэрэгцэж ирлээ. Дэлхийн хэмжээний хөрөнгө оруулалтын төслөөс хамаарсан үйлдвэрлэл тэлж, бүс нутгийн хөгжил өнгө төрхөө 38 сарын дотор 180 градус хувирсан болохыг говийнхон мэднэ, тэнд очсон монголчууд андахгүй. Улсын төсөвт гурав жилийн хугацаанд 803 сая ам.долларыг зөвхөн татварын орлогоор өгсөн нь хөрөнгө оруулалтын гэрээний үр өгөөжийг тоогоор илэрхийлэх том хариулт боллоо.

Монголын эдийн засагт 6.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авчирсан гэрээний дүнд Баяжуулах үйлдвэр сая өрхөө татав. XX зуунд байгуулсан аж

үйлдвэрийн түүхэн хувьсгалын галыг ноцоож, XXI зууны үр сад нь шинээр цогцлоон бүтээлээ. Цахилгааны сааталд ороод байсан баяжуулах үйлдвэр Хятадын хойд захын Баяннуур аймгаас 220 кВт-ын цахилгааны эх үүсвэр авч, эрчим хүчтэй боллоо. Нийтдээ 200 орчим км-ын цаанаас эрчим хүчээ татаж буй Оюутолгойн баяжуулах үйлдвэр нь цагт 88 мянган тонн буюу жилдээ 700 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадал жигдрэв.

Нэгэн цагт хөрөнгө оруулагчдын хараанд өртөж, тэдний нүдийг хужирлаж явсан Оюутолгой орд өнөөдөр эдийн засгийн эргэлтэд орж, анхны бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх гэж байгаа нь энэ. Үндэсний бахархал гэж хэлж болох Оюутолгой төслийн бүтээн байгуулалтад 44 орны 15 мянган иргэн оролцож, өмнийн говьд аж үйлдвэрийн шинэ хотыг сүндэрлүүлж байна. Жилд 35 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай Баяжуулах үйлдвэрийн “хөдөлгүүр” асаж, Монголын эдийн засгийн тулах цэг болж байна. Өмнийн говьд 36 сарын хугацаанд сүндэрлэсэн Оюутолгойн баяжуулах үйлдвэрт 3000 хүн ажиллана. Үүний 90 хувь нь хөрөнгө оруулалтын гэрээний дагуу монголчууд байх юм. Баяжуулах үйлдвэр анхны баяжмалаа үйлдвэрлэж, ирэх оны эхний хагаст төлөвлөсөн ёсоор бүтээгдэхүүнээ олон улсад худалдаална. Нэмүү өртөг шингээсэн, Оюутолгой ордын дээж бүтээгдэхүүн хоёрдогч зах зээлийг зорих цаг хугацаа айсуу. ■



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

# Мэндчилгээ



*22 жилийн турхтай Монголын хамгийн том банкны  
Эрхэм Харууцагч Т.Са бүхэн 2013 ондоо бизнесийн  
арвин оролттой, ажлын өрнүүлэн амжилттай, эрүүл энхийн  
гэгээн жаргалтай, эрч хүч, баар баясгаар бүрхэн байхын  
дээдийн ерөөлийн нийт хамт оныхоо өмнөөс өргөн  
дэвшүүрж байна.*



*Түшицэтгэх захирал*

A handwritten signature in black ink, appearing to be "T. Sa".

*Т. Мадраа*





ҮЛГЭР ДУУРИАЛАЛ

# ЗАМЫН ЦАГДААД БАЯРЛАДАГ ШҮҮ

И.ОТГОН

...Нийслэлийн гэрээт хөдөлгөөний хяналтын хэлтэс гэж хоёр тасагтай 120 хүнтэй бүрэлдэхүүнээр замын цагдаа хүч сэлбэжээ. Ингэснээр нэг замын цагдаагийн хариуцдаг нэгж нутаг дэвсгэрийн хэмжээ хумигдах, цаасан дээр байдаг ажлын норм нормативыг мөрдөхөд дөхөмтэй болсон гэсэн үг...

Сонгуультай, газар шорооны ажил ундарсан, энд тэндгүй зам засвар өрнөж, дээр нь халуун нар шараад л мөн ч хэцүүхэн байдалтай өнгөрсөн зуныг үдсэн дээ нийслэлчүүд маань. “Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй” гэдэгчлэн шинэчлэлийн Засгийн газрыг эмхлэн зохион байгуулах сиймхийгээр хаа сайгүй цалгар назгай байдал үүссэн үед нэг л байгууллага “Овоо доо” гэж олзуурхахаар ажиллаж, олон түмнээс талархал хүлээж байв. Тэр бол Замын цагдаагийн ерөнхий газар. Тийм ч учраас “Mongolian Economy” сэтгүүл 2012 онд хамгийн сайн ажилласан байгууллагаар Замын цагдаагийн ерөнхий газрыг нэрлэж байна. Өвлийн тэсгим хүйтэнд ч, зуны аагим халуунд ч ажлын байрандаа буюу зам дээр зогсож байдаг замын цагдаа нарын ажлын хариуцлага өндөр. Төрийн тусгай алба, цагдаагийн алба юм чинь тэгэлгүй дээ гэж Та бодож магад. Хэдий тийм ч сиймхийг ашиглаад

нийтийн жишгээр назгайрч бас болно оо доо тэд. Гэхдээ тэгээгүй учраас оны хамгийн сайн ажилласан байгууллагаар хэвлэлийн хуудаснаа бичигдэж байна. Тэдний ажил ард түмэнтэй цаг ямагт хамт байдаг учраас олон нийтийн зүгээс замын цагдаагийн ажилд тавих дүнг ч олж мэдэх амархан.

## “Хот” цагдаа хоёрын нөхөрлөл

Тэдний ажлыг зүгээр нэг ажиглалтаараа өнгөц үнэлэхийг хүссэнгүй. Өнгөрч буй онд хотын замын хөдөлгөөний зохицуулалтад ямар шинэ өөрчлөлтүүд гарсан бэ гэдгийг саная. Намар хичээл сургууль цуглаж ид хөдөлгөөн ихсэх үеэр цэнхэр хантаазтай хүмүүс гарц, гэрлэн дохион дээр зогсож, хөдөлгөөн зохицуулж, замын цагдаагийн ажилд тусалдаг болсон. Түүнчлэн өнгөрсөн зун энд тэндгүй



► зам засварын ажил хийгдсэн ч түгжирч түүртэх нь харьцангуй бага байна гэлцсэн. Мөн Улаанбаатар хотын шинэ удирдлагуудын зүгээс хотын замын хөдөлгөөнийг сааруулах зоримог тогтоол, шийдвэр, дүрэм журам гаргасан нь замын цагдаа нарын ажлын ачаалал, үүрэг хариуцлагыг улам бүр нэмэгдүүлсэн. Замын ачааллыг сааруулахын тулд автомашиныг улсын дугаарын сүүлчийн тоогоор нь хязгаарлаж хөдөлгөөнд оролцуулах, нийтийн тээврийн автобусыг нэгдүгээр эгнээгээр зорчуулж хэвшүүлэх хоёр сарын аян, бага сургуулийн хүүхдийг автобусаар зөөх тухай захирамж тушаал амжилттай хэрэгжиж, олон нийтийн зүгээс “иргэдэд чиглэсэн чухал арга хэмжээ болсон” гэж өндөр үнэлгээ авсан нь замын цагдаагийн хүнд хөдөлмөрийн

үр шим юм. Тухайлбал, өнгөрсөн наймдугаар сарын 27-ноос аравдугаар сарын 27 хүртэлх дээрх аяны хүрээнд замын цагдаа нар уртасгасан цагаар нойр хоолгүй шахам ажиллажээ. Энэ хугацаанд автотээврийн ослын дуудлага 20-30 хувиар буурсан тухай сайн мэдээ Замын цагдаагийн ерөнхий газрын мэдээлэлд тэмдэглэгдсэн байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ч хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулахын тулд Замын цагдаагийн ерөнхий газартай нягт хамтарч, тэдний ажлыг дэмжиж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, энэ онд Нийслэлийн гэрээт хөдөлгөөний хяналтын хэлтэс гэж хоёр тасагтай 120 хүнтэй бүрэлдэхүүнээр замын цагдаа хүч сэлбэжээ. Ингэснээр нэг замын цагдаагийн хариуцдаг нэгж нутаг дэвсгэрийн хэмжээ хумигдах,

цаасан дээр байдаг ажлын норм нормативыг мөрдөхөд дөхөмтэй болсон гэсэн үг.

## “Иргэн Та ч замын цагдаа”

Өнгөрсөн зун ширүүн бороонд шалба норон ажлаа хийж зогсоо нэгэн замын цагдаа залуугийн зураг facebook, twitter хуудсаар олныг шуугиулсныг та бүхэн санаж байгаа байх. Энэ нь иргэдийн зүгээс маш их талархлын үгтэй сэтгэгдэл “цуглуулж” замын цагдаагийн хүнд ажлыг үнэлэх, өмөлзөх сэтгэл олон түмэнд төрсөн билээ. Замын цагдаагийн ерөнхий газраас өнгөрч буй онд нийслэлийн зам тээврийн хөдөлгөөний аюулгүй ажиллагааг сайжруулах үүднээс хэрэг зөрчлийн талаар иргэдээс мэдээлэл авч ажиллахад нэлээд анхаарсан байна. Өөрөөр хэлбэл, хотын замын хөдөлгөөнд оролцож яваа иргэн Та ч замын цагдаа гэсэн ойлголтыг бий болгож, үйлчлүүлэгчиддээ ойртсон нь хэрэг зөрчлийг цаг алдахгүй илрүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хянахад ихээхэн эерэг нөлөө үзүүлсээр байгаа аж. Иргэдийн санал гомдлыг хүлээн авах шууд утас ажиллуулахаас гадна facebook хуудас нээсэн нь замын хөдөлгөөний зөрчилтэй холбоотой мэдээллийг иргэд шууд газар дээрээс нь баримтжуулан дамжуулах байдлаар том дэвшил болсон байна. Замын цагдаагийн өглөөний ээлж 07.00-14.00 цаг, оройн ээлж нь 14.00-21.00 цаг хүртэл аюулгүйн манаанд зогсдог бол шөнийн ээлж нь 20.00-08.00 цагийн хуваарьтай ажилладаг байна. Тэдэнд бүх нийтийн амралтын өдөр болоод баяр ёслолын үеэр амсхийх, баярлах цаг тун хомс. Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн тоог сонин хэвлэлд янз бүрээр мэдээлдэг. Харин хамгийн сүүлд Замын цагдаагийн газрын шинэчилсэн мэдээллээр бол нийслэлийн замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн тоо 300 гаруй мянгад хүрсэн байна. Унтах нойр, амрах завгүй явдаг замын цагдаа нар өнөөдрийн олсон амжилтаа улам бататгаж ажиллахыг хүсэн ерөөе. ■



САЛБАДАЙН ДУРАНД

## ЭМЯ-НЫХАН ИЛ ГАРААРАЙ



Б.МАРТ

...Нуруу нь өвдөж ирсэн өвчтөнд “Хөлийн чинь сарвууны яс гэмтжээ” гэсэн онош тавихгүйн тулд, ихэр хүүхдийн нэгийг нь чагначихаад нөгөөг нь хүйгээ ороосныг мэдэлгүй, хоёуланг нь хөнөөхгүйн тулд мэдлэг, чадвараа зузаатгаарай, эмч нараа...



Өвлийн өвөөг дагаж ирсэн салбадайннууд шооч дурангаараа тэр онд хамгийн муу сурсан, сахилга батгүй, хэлсэн амандаа хүрдэггүй, ам, ажил нь дандаа зөрдөг муу сурагчийг дуранддаг даа. “Mongolian Economy” сэтгүүл ч өнгөрсөн онд аль байгууллага хамгийн муу ажилласан байна вэ гэж дурандлаа. Дуранд туссан Эрүүл мэндийн салбарынхан бусдын араар шургалах, буруу харж зогсох гэж үзсэн ч тодоос тод харагдсаар байв. Нүүрээ дутуу угааж, хувцсаа халтартуулсан, аавынхаа өгсөн мөнгийг цоорхой халаасандаа хийгээд гээчихсэн, даалгавраа хийгээгүй жаал шиг нэг гараараа нуухтай нүдээ нухлан, нөгөөгөөрөө шилээ илэн зогсох эрүүл мэндийн салбарынхныг ирэх онд шилдэг болоорой гээд алдаа дутагдлыг нь тоочлоо.

Монгол Улс оршин тогтнох үндэс суурь болсон хамгийн чухал салбарын хувьд эмч, сувилагч, мэргэжилтнүүд авлигаас ангид байж, ирсэн өвчтний халаас, гарыг харалгүй, онош тавьж, хамаатан, найз нөхөд, эсвэл ээжийнхээ ажиллуулдаг эмийн санг зааж өгөх бус эдгэрэхэд найдвартай аргыг зөвлөдөг болоорой, эрүүлийг хамгаалахынхаан. Өвчиндөө дарлагдаж, ярих тэнхэлгүй болтлоо эцэж, ядарсан түмнийг элдэв үгээр гоочилж, өмссөн зүүснээр нь ялгаж,

хэлтэй, хэлгүйгээр нь ялгаварлаж, танил болоод гар хүндрүүлсэн нэгэнд илүүтэй үйлчилж, амь нас нь дээсэн дээр дэнчигнэж буй нэгнийг хяламхийж, хаалганы цаана орхихгүй байгаарай, эмч, сувилагчид аа.

Нуруу нь өвдөж ирсэн өвчтөнд “Хөлийн чинь сарвууны яс гэмтжээ” гэсэн онош тавихгүй байхын тулд, ихэр хүүхдийн нэгийг нь чагначихаад нөгөөг нь хүйгээ ороосныг мэдэлгүй, хоёуланг нь хөнөөхгүйн тулд мэдлэг, чадвараа зузаатгаарай, эмч нар аа.

Чагнуур, халууны шилнээс өөр багажгүй эмч нараас эд, эсийн хэмжээний онош хүлээж, чамлах нь өрөөсгөл байна. Хамгийн чухал салбарын хувьд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг яаралтай бүрдүүлэхгүй бол үеэ элээж, хугацаа нь дууссан тоног төхөөрөмжүүд өвчин оношлох нь байтугай арчиж зүлгээд ч ажиллаж “хүчрэхээ” ч больсон байна шүү, эрхэм бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчид аа.

IV зэргийн түлэгдэлт гэдэг нь бүх бие нь түлэгдэж, арьс нь умайж, татаад ярих нь битгий хэл амаа ч хөдөлгөж чадахгүйд хүрэхийг хэлнэ гэж Түлэнхийн үндэсний төвийн эмчилгээ хариуцсан орлогч эрхлэгч Б.Бат-Оргил ярьсан. Тэгвэл Түлэнхийн үндэсний төвийн барилгын дүр төрхийг IV зэргийн түлэгдэлттэй хүнтэй

зүйрлэж болохоор байна. Барилгаа засаж, сэргээх төсөв байхгүй гээд өвчтнүүдээ Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нэг тасагт шилжүүлээд удаж байна. Нийслэлд өдөрт дунджаар 15-20 хүн их, бага хэмжээгээр түлэгддэг байна. Халдварын онцгой дэглэмд байх учиртай өвчтөнүүд бие биенээсээ халдвар авч, улмаар амь насаа алдах нь энүүхэнд гэнэ. Түүнчлэн төрөх эмнэлгүүдийн орны хүрэлцээ, орчны ариун цэвэр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн өвчтөн, сахиурууд холилдсон байдал, III шатлалын гэгдэх улсын эмнэлгүүдийн ачаалал жилээс жилд 20-30 дахин нэмэгдэж байгаа гээд энэ салбарт орчин үеийн эмнэлгийн зориулалттай барилгын төсөв нэн шаардлагатай байна, эрхэм түшээд ээ.

Тус салбарт энэ мэт үндсээр нь шинэчилж, сайжруулах, анхаарах зүйл олон байгааг шооч дуран үргэлжлүүлэн дуудсаар байсан юм. Төгсгөлд нь, өвдөж, зовсон ард иргэд эрүүл мэндийн салбарын энэхүү алдаа дутагдлыг даруй засаж, ирэх онд эрүүл иргэдтэй Монгол Улс болохын тулд эрс шинэчлэл хийж, эрүүлжээсэй хэмээн өвлийн өвөөд захидал ирүүлснийг ийнхүү дурдлаа гэсэн юм. ■

ШИНЖЭЭЧ БИЧИЖ БАЙНА

# МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ 2013 ОНД



Л.БЯМБАА /УМС компанийн эдийн засагч/

## Дэлхий

Улирч буй 2012 онд хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт саарч, зарим тохиолдолд бүр буурч байхад хөгжиж буй орнууд хэр зэрэг эсэргүүцэлтэй байж чадах вэ гэдэг гол асуулт байлаа. Харамсалтай нь тийм ч дархлаатай байж чадаагүй бөгөөд Хятадын эдийн засаг зуны саруудад нэлээд бууралттай байлаа. Энэ нь Евро бүсийн хүндрэлд орсон орнуудын асуудал төдийлэн амжилттай шийдэгдэхгүй, мөн бусад хөгжилтэй орны сэргэлт хурдацтай явагдаагүйгээс болсон сааралт юм.

Олон улсын томоохон байгууллага, банкууд энэ оны болон ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг дараах байдлаар таамагласан байна.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн таамаг 2012, 2013 онд, хувиар

	Дэлхий		АНУ		Евро бүс		Хятад	
	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012
ОУВС	3.3	3.6		2.2		1.6	9.3	9.1
Дэлхийн банк		3.6	2.1	2.1	-0.1	-0.4	7.9	8.5
АХБ			2.2	1.9	0.8	-0.7	7.7	7.4
Фитч		2.4		1.8		0.4	9	8.5
Голдмэн Сакс		3.2		2		0.1	9.1	8.6
Стандарт Чартеред		2.2		1.7		-1.5	9.2	8.1
Ситибанк	2.7	2.5	2.5	3.8	-0.4	-1.4	7.6	7.7


Эх сурвалж: дурдсан байгууллагуудын эдийн засгийн тайлан, 2012 оны 11-12 сар

## Монгол 2012 онд


Гадаад орчны таагүй байдал Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлснийг, эдийн засгийн суурь үзүүлэлт хэр эрүүл байгааг харуулдаг матриксаас үзье. Боломжит долоон онооноос 2012 оны гуравдугаар улирлын байдлаар

3.5 оноо авсан байгаа нь өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлт бөгөөд гадаад худалдааны алдагдал оноог хамгийн ихээр доош татсан байна. Энэ нь Хятадын эдийн засаг, мөн манай экспортын түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ ханшийн уналттай шууд холбоотой байлаа.

Түүхий эдийн ханш дэлхийн зах зээл дээр оны эхнээс унасан



2012 оны эрдэс, бүтээгдэхүүний экспортын өөрчлөлт /2011 оны мөн үеийнхтэй харьцуулснаар/




► 2012 оны эцсийн гүйцэтгэлээр банкны салбар болон валютын ханшийн тогтвортой байдлаар бусад үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад дордсон төлөвтэй байна. Үүнд инфляцийн түвшин, гадаад худалдааны болон төсвийн алдагдал хэт өндөр байгаа нь голлон нөлөөлөхөөр байна. ДНБ-ий өсөлт оны эцэст 12 орчим хувийн гүйцэтгэлтэй гарахаар байна.

## 2013 оны чиг хандлага ба нөлөөлөх хүчин зүйлс

Эдийн засгийн төлөв байдалд улс төрийн тогтвортой байдал, мөн үүнтэй холбоотойгоор засгийн газар мөрийн хөтөлбөрөө тууштай хэрэгжүүлэх боломж нь чухал нөлөө үзүүлэхээр байна. Төрийн эдийн засагт үзүүлэх нөлөө өндөр байх нь, учир нь улсын болон нийслэлийн төсвөөс хийх хөрөнгө оруулалтыг нэмэх бодлого баримталж байгаа бөгөөд Засгийн газрын бондын санхүүжилтээр хийгдэх дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд чухал үүрэг гүйцэтгэхээр харагдаж байна.

Төсвөөс санхүүжүүлж буй хөрөнгө оруулалтын өсөлт /Сая төгрөгөөр/



Эх сурвалж: СЯ, Төсвийн төсөл, 2012.09 сар

Мөнгөний бодлого эдийн засагт эерэг нөлөө үзүүлж болзошгүй, учир нь мөнгөний бодлого инфляцийг онилсон хэвээр, гэхдээ энэ удаад зорилгодоо дөхөх боломжтой гэж үзэж байгаа. Учир нь төрөөс төсвийн зардлыг хязгаарлаж, ДНБ-д төсвийн эзлэх хувийг 40-өөс илүүгүй, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлыг хоёр хувиас илүүгүй байлгах аар төлөвлөж байгаа. Мөн Монголбанкны зүгээс хэд хэдэн бодитой арга хэмжээ авч эхэлсэн нь 2013 онд инфляцийг бууруулахад бодит түлхэц үзүүлэх боломжтой. Тухайлбал, түлш, шатахуун, цахилгаан эрчим хүч зэрэг бусад бараа, бүтээгдэхүүний үнэд

зохицуулалт хийх, цалин, тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмэх гэх мэт арга хэмжээг дурдаж болно. Энэхүү бодлого нь инфляцийг бууруулж, хэрэглэгчдийн нуруун дээрх ачааг нимгэлэх ч гэлээ бизнес эрхлэгчдийн гол зовлон болоод буй зээлийн хүү, санхүүжилтийн зардлыг бууруулахад нөлөөгүй юм. Мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр, Монголбанк бодлогын хүүг өндөр хэвээр хадгалж, зээлийн хүү буурах боломж бүрдэхгүй юм.

Инфляци




Жил ирэх бүр улам томроод байгаа гадаад худалдааны алдагдал ирэх жил хумигдах төлөв ажиглагдахгүй байна. Хэдийгээр өмнөх жилүүдийн гол импорт болох уул уурхайн хүнд тоног төхөөрөмжийн импорт буурах боловч зам барилгын бүтээн байгуулалттай холбоотой машин механизмын импорт өсөх нь. Түүн дээр нэмэгдээд түлшний хэрэглээ 20 хувиар нэмэгдэнэ гэсэн таамаг бий. Экспортын орлогын хувьд гол түүхий эд болох нүүрсний үнэ төсөвт сууснаас доош орохгүй тогтвортой байж чадвал дор хаяж 25 хувиар өсөх боломж бий. Хэмжээний хувьд нүүрс энэ жилийнхтэй адил, харин зэс хоёр дахин ихийг экспортод гаргахаар байна. Үүнд мэдээж, Оюутолгойн зэс олборлолт нөлөөлнө. Дүгнэж хэлбэл, гадаад худалдааны алдагдал буурахгүй ч, нэмэгдэхгүй л болов уу.

2013 оны чиг хандлагад хамгийн их нөлөө үзүүлж болзошгүй хүчин зүйл нь Оюутолгойг тойрсон асуудал болоод байна. Талууд зөвшилцөлд хүрч чадахгүй уурхайн үйл ажиллагаа гацаанд орвол эдийн засаг доголдох магадлалтай. Оюутолгойгоос гадна, стратегийн салбар дахь Хөрөнгө оруулалтын зохицуулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хэмжээ огцом буурч шинэ хөрөнгө оруулалт, төсөл хийгдэхгүй байгаагаас ДНБ-д хамгийн том хувь эзлэх уул уурхайн салбар нийтдээ уналтад орж болзошгүй нь болоод байна. ►



► Гадаадын шууд хөрөнгө оруулалт ийнхүү буурч, валютын дотогшлох урсгал саарч, гадагшлах нь эрчимжих хандлагатай байгаа ч Засгийн газар олон улсын зах дээр бонд гарган валютын урсгалыг нэг зүгт чиглүүлээ. 2013 онд валютын ханш аажмаар буурч, 1250 болох магадлалтай болж байна. Гэхдээ ам.долларын ханш огцом биш аажмаар сулрах болов уу. Учир нь, Монголбанк нефть импортлогчдод ам.долларын бага хүүтэй зээлийн шугам нээж өгсөнөөр арилжааны банкуудын хамаг валютыг үе үе хамдаг байдал арилж, ханшийн хөдөлгөөн харьцангуй тогтвортой болоод байгаа. Ханш буурах тренд жилийн турш хадгалагдана.

Ам.долларын ханш ба валютын томоохон урсгал



2013 оны үндсэн үзүүлэлтүүдийн таамаг


Үзүүлэлт	2012*	2013**
ДНБ-ийн өсөлт, хувь	12.7	10***
Инфляци, хувь	15	10
Зээлийн хүү, хувь	18	18
USDМNT, оны эцэст	1350	1250
Чанаргүй зээлийн хэмжээ, хувь	4.7	8

\*2012 оны гүйцэтгэлийн урьдчилсан таамаг

\*\*2013 оны таамаг

\*\*\*Оюутолгойн төсөл бүрэн хэрэгжиж чадвал ДНБ 17 хувь хүрэх боломжтой

Дээрх таамаг, төсөөллийг ашиглан дүгнэхэд, 2013 онд эдийн засгийн эрүүл мэндийн үзүүлэлт дараах байдалтай гарах магадлалтай байна.



Энэ тохиолдолд ерөнхий оноо энэ жилийнхээс арай өндөр буюу 4.2 оноотой гарах боломжтой.

Макро эдийн засгийн эрсдэл 2013 онд

Өндөр	<ul style="list-style-type: none"> <li>Валютын ханшийн хэлбэлзэл нэмэгдэх</li> <li>Инфляци өсөх</li> <li>Хөрөнгө оруулалтын сөрөг урсгал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зуд болж мал олноор хорогдох</li> <li>Барилгын сектор муудах</li> <li>Төсвийн алдагдал өндөр гарч, төсвийн тогтворгүй байдал үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төр эдийн засагт хэт оролцох</li> <li>Хөрөнгө оруулагчдын нөхцөл муудах, уул уурхайн салбар доголдох</li> </ul>
Дунд зэрэг	<ul style="list-style-type: none"> <li>Хятадын шинэ засаг Монголд тааламжгүй бодлогын чиг баримжаатай болох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Банкуудын хөрвөх чадвар муудах</li> <li>Зээлийн олдоц муудаж, эдийн засгийн эргэлт саарах</li> <li>Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах</li> <li>Гадаад худалдааны алдагдал нэмэгдэх</li> </ul>
Бага	<ul style="list-style-type: none"> <li>Манайд болон хөрш зэргэлдээ орнуудад халдварт өвчин, эпидеми гарах</li> <li>Байгалийн гамшиг тохиолдох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ОХУ-аас импортлох түлшний үнэ нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дэлхийн эдийн засаг сэргэхгүй удах</li> </ul>
Бага		Дунд зэрэг	Өндөр

ФОТО СУРВАЛЖЛАГА

# “ГАЦУУРЫН УРАЛДААН”

Улаанбаатарын сүрлэг барилгуудын гаднах ганган гацуурууд айсуй оныг угтан өмнөх жилүүдээс улам бүр өнгө жавхаа нэмж, шөнийн ододтой өнгө сүлэлдэх аж. Манай фото сурвалжлагчийн дуранд хотын ганган гацуурууд ийн буужээ.





ӨРХИЙН ТӨСӨВ

## БАЯРЫН ШИРЭЭ



Манай улсын хувьд тэмдэглэлт баярын тоо хэрээс хэтэрсэн гэхэд хилсдэхгүй. Ядуу амьдралтай иргэдийн хувьд зөвхөн түлээ, нүүрсний хэрэглээ нь л өрхийн орлогын талаас илүү хувийг аваад явчихдаг өвлийн улиралтай зэрэгцээд, баяр ёслол тэмдэглэх нь өрхийн төсөвт хямрал дагуулдаг гэдэг. Чингэлтэй дүүргийн иргэн Д.Октябрь “Бидний хувьд яалт ч үгүй тэмдэглэх хэд хэдэн баяр байх юм аа. Тухайлбал, наадам, шинэ жил, цагаан сар. Гэхдээ энэ гурван баяр хамгийн их зарлагатай нь байдаг. Өдрийн хоолондоо хүрдэггүй орлоготой манайх шиг айлд хамгийн хэцүү асуудал бол тэмдэглэлт баярууд. Болдогсон бол тэмдэглэхгүй баймаар л байдаг юм. Гэхдээ бусад хүмүүс баярлаж, цэнгээд байхад хэдэн хүүхдээ баярлуулахгүй бол болохгүй биз дээ. Тиймээс зээл авч байгаад ч болсон тавгийн чихэртэй суух хэрэгтэй” гэсэн юм. Шинэ жил ойртож байгаатай холбогдуулан манай сэтгүүл “Өрхийн төсөв” буландаа гурван өөр түвшний буюу ядуу, дундаж, дунджаас дээгүүр өрхийн баярын ширээг сонирхуулж байна.



Овог нэр: Ш.Ундрах  
Ам бүл: гурав  
Өрхийн сарын дундаж орлого:  
3.000.000 төгрөг

**1. Шинэ жилийн мод:**

Долоон жилийн өмнө 500.000 төгрөгөөр ОХУ-аас худалдаж авсан.

**2. Чимэглэл**

Нийт үнэ: Мөн долоон жилийн өмнө 400.000 төгрөгөөр Италиас худалдаж авсан.

Нэгжийн үнэ дунджаар: 10.000-20.000 төгрөг. **Одоогийн ханш дунджаар:** 1 200 000 төгрөг.

**3. Шинэ жилийн бэлэг**

Нийт үнэ: 250.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 50.000 төгрөг

Төрөл: Аав, ээж, хүүгийнхээ дуртай бэлгийг авч өгнө

**4. Тавгийн чихэр**

Нийт үнэ: 50.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 13.000-14.000 төгрөг

Төрөл: Орос чихэр

**5. Ундаа**

Нийт үнэ: 40.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 3.000-4.000 төгрөг

Төрөл: Солонгос жүүс, хүүхдийн ундаа

**6. Жимс**

Нийт үнэ: 70.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 10.000

Төрөл: Алим-орос, лийр- орос, мандарин, усан үзэм

**7. Зууш**

Нийт үнэ: 50.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 10.000 төгрөг

Төрөл: Гахайн утсан мах, хиам, бяслаг, даршилсан ногоо, өргөст хэмх, улаан лооль

**8. Хоол**

Нийт үнэ: 150.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 15.000 төгрөг

Төрөл: Гахайн хавирга, бууцай, соус, будаа, төмс, загас

**9. Оргилуун дарс**

/Бусад төрлийн хатуу дарс/

Нийт үнэ: 50.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 25.000 төгрөг

Төрөл: Оргилуун дарс-орос, Улаан дарс

**10. Бялуу**

Нийт үнэ: 40.000 төгрөг

Төрөл: Захиалгаар

**11. Салют:** Авдаггүй**12. Бусад**

Нийт үнэ: 600.000 төгрөг

Төрөл: Гэр бүлийн гишүүдийн албан байгууллагын шинэ жилийн арга хэмжээ, шинэ жилийн гоёл.





Овог, Нэр: Д.Нарангэрэл  
Ам бүл: дөрөв  
Өрхийн сарын  
дундаж орлого:  
1.500 000 төгрөг

#### 1. Шинэ жилийн мод:

120.000 төгрөг

#### 2. Чимэглэл

Нийт үнэ: 30.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 2000 төгрөг

#### 3. Шинэ жилийн бэлэг

Нийт үнэ: 190.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 8.000 төгрөг

Төрөл: “Оргил” худалдааны төвөөс шинэ жилийн бэлэг тус бүрээс 10 ширхэгийг худалдаж авна.

#### 4. Тавгийн чихэр

Нийт үнэ: 50.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 15.000-18.000 төгрөг

Төрөл: Орос том чихэр

#### 5. Ундаа

Нийт үнэ: 20.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 3.000 төгрөг

Төрөл: Төрөл бүрийн жимсний шүүс, лаазтай ундаа

#### 6. Жимс

Нийт үнэ: 40.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 8.000 төгрөг

Төрөл: Мандарин, алим, усан үзэм, гадил,

#### 7. Зууш

Нийт үнэ: 40.000 төгрөг

Төрөл: Өндөгний зууш, шинэ ногооны болон төмсний зууш

#### 8. Хоол

Нийт үнэ: 50.000 төгрөг

Төрөл: Холимог хуурга, бууз, тахианы шарсан мөч

#### 9. Оргилуун дарс

/Бусад төрлийн хатуу дарс/

Нийт үнэ: 50.000 төгрөг Нэгжийн үнэ дунджаар: 15.000 төгрөг

Төрөл: Алтан чингис, улаан дарс, оргилуун дарс

#### 10. Бялуу

Нийт үнэ: 25.000 төгрөг

Төрөл: “Батбайгаль”-ийн жимстэй бялуу

#### 11. Салют

Нийт үнэ: 25.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 5.000-7.000 төгрөг

Төрөл: Янз бүрийн

#### 12. Бусад

Нийт үнэ: 350.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 30.000 төгрөг

Төрөл: Үзвэр үйлчилгээ, гэр бүлийн гишүүдийн албан байгууллагын шинэ жилтэй холбоотой зардал.



Овог, Нэр: Д.Октябрь  
Ам бүл: дөрөв  
Өрхийн сарын дундаж орлого:  
130.000 төгрөг

#### 1. Шинэ жилийн мод:

Байхгүй

#### 2. Чимэглэл:

Байхгүй

#### 3. Шинэ жилийн бэлэг:

Авдаггүй

#### 4. Тавгийн чихэр:

Нийт үнэ: /5.000 төгрөг/

Нэгжийн үнэ дунджаар: /5.000 төгрөг/

Төрөл: Төрөл бүрийн чихрээс холиод нэг килограмм

#### 5. Ундаа

Нийт үнэ: 3.300 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 1.100 төгрөг

Төрөл: Бидний ундаа-“Fanta”, “Coco cola”

#### 6. Жимс

Нийт үнэ: 6.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 3.000 төгрөг

Төрөл: Нэг килограмм алим, нэг килограмм мандарин

#### 7. Зууш

Нийт үнэ: 10.000 төгрөг

Төрөл: Өргөст хэмх, алаг салат, 500 грамм хиам

#### 8. Хоол

Нийт үнэ: 10.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 5.000 төгрөг

Төрөл: Бууз

#### 9. Оргилуун дарс

/Бусад төрлийн хатуу дарс/

Нийт үнэ: 6.000 төгрөг

Нэгжийн үнэ дунджаар: 6.000 төгрөг

Төрөл: Нэг шил “Хараа” архи

#### 10. Бялуу

Нийт үнэ: 8.000 төгрөг

Төрөл: “Суман гүн” үйлдвэрийн бялуу нэг ширхэг

#### 11. Салют:

Авдаггүй

#### 12. Бусад:

Гэр бүлээрээ үдшийг өнгөрүүлдэг



## МАНАЙ НИЙТЛЭЛИЙН ДАРАА

Манай сэтгүүл өмнөх дугаартаа элэгний өвчлөлийн асуудлыг хөндөж, элэг шилжүүлэн суулгах хагалгаа хийхэд тулгарч буй асуудлаар редакцийн уулзалт зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын хүнд суртал болоод Монголын болоод БНСУ-ын эмнэлэгүүдийн тухай “Тэнгэр, газар шиг ялгаатай Монгол Солонгосын эмнэлгүүд”, “Элэгний өвчин ба амьдрал” зэрэг сурвалжлага, ярилцлагуудыг хүргэсэн билээ. Энэхүү дугаар маань төрийн удирдах түвшин болоод ард иргэдийн сонорт хүрч, Элэг шилжүүлэн суулгах үндэсний төвд нэн шаардлагатай байсан 1.2 тэрбум төгрөгийг 1.6 тэрбум болгож, мөн ясны чөмөг шилжүүлэн суулгахад шаардлагатай 2.6 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар боллоо.

Энэ тухайд Элэг шилжүүлэн суулгах үндэсний төвийн захирал О.Сэргэлэн “Засгийн газрын нөөц

сангаас 4.2 тэрбум гаруй төгрөг төсөвлөж, бидний үйл ажиллагаа болоод иргэдийнхээ эрүүл мэндэд үнэтэй хувь нэмэр оруулсанд манай багийн эмч нар гүнээсээ талархаж байна. Түүнчлэн танай сэтгүүлийн хамт олонд биднийг шаардлагатай төсвөө унагчихаад, хэнд хандахаа мэдэхгүй явж байхад сурвалжилж, нийтэд дэлгэн, олны дэмжлэг авахын зэрэгцээ, УИХ-ын гишүүдэд ойлгуулж өгсөнд мянга мянган өвчтнийхөө өмнөөс баярлаж байгаагаа хэлмээр байна. Бид өнөөдрөөс шаардлагатай багаж, төхөөрөмжүүдээ авах талаар хөөцөлдөж эхэлнэ. Шаардлагатай зүйлсээ нэн даруй авч, иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг цаг алдалгүй аврах гээд догдолж байна” гэлээ. Элэгний асуудал хөндсөн нийтлэл, сурвалжлагуудын талаар уншигчдаас олон арван сэтгэгдэл, зөвлөмж манай редакцид ирсээр байна. Заримаас нь хүргэж байна.

### Уншигч:

Монголд дундаж эмчид уурхайчны цалингаас дутуугүй цалин өгөхөөс нааш чанар шаардах нь утгагүй болчихоод байгаа юм. Хүний амь нас, эрүүл мэнд хариуцдаг хүн өндөр цалинтай байж хариуцлагаа ухамсарлаж, ажлаа сайн хийнэ. Гаднын орнуудад эмч, эмнэлгийн салбарт ажиллагсдыг өндөр цалингаар туршлагажуулж, хариуцлагатай болгодог гэдгийг эрхэм түшээд анхаараасай.

### Болд:

Сануштай юм бичжээ. Төр, засаг эрүүл мэндийн салбараа харах цаг болсон. Монголчууд маш их стресстэй болж байна. Нийгэм ийм байхад ядаж эрүүл мэндийн салбартаа шинэчлэл хийх хэрэгтэй байна шүү дээ. Үүнийг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж анхаарч, ямар нэг зүйл хийгээсэй. Эрүүл монгол хүн зэрэг аян бол хэрэггүй шүү. Хүндээ хүрэхгүй аян зохиож, мөнгө дэмий хийсгэхгүй байвал зүгээр байна.

### Соёл:

Зөвхөн эрүүл мэндийн салбар ч бус бусад салбарт харилцаа, ёс зүй, үйлчилгээний соёл дутагдаж байна. Үүнийг хүн бүр мэдэж байгаа ч энэ байдалдаа бүр дасчихсан. Хамгийн чухал нь дарга, даамал, төрийн түшээдэд бол бөхөлзөж өгнө дөө, аль ч салбарынхан. Ийм хэвшмэл сэтгэлгээг яаж арилгах вэ, хүмүүс ээ. Гадаадад амьдарч байгаад ирсэн хүн үйлчилгээний дутагдлаас болоод эх орондоо амьдрахаас дургүй нь хүрч, зугтаж байна шүү дээ.

### Уншигч:

Төр түшиж байгаа томчууд нь ханиад хүрэхээрээ гадагшаа нисээд л, гаднын оронд эмчлүүлчихэж байгаа болохоор Монголын эрүүл мэндийн салбар хэрхэн сөхөрч, байдал ямар байгааг мэдэхгүй шүү дээ. Мөнгөгүй, ядарсан монголчууд нь эмнэлгүүдээрээ үйлчлүүлэх гэхээр цалингаа голж, цаг нөгцөөсөн эмч нар нь үзэж өгөхгүй, техник, хэрэгсэл нь зөв ажиллахгүй байдалд л байна шүү дээ. Үүнийг томчуудад яаж ойлгуулах вэ. УИХ-ын гишүүдийг нэг бүрчлэн эмнэлгээр явуулж, зовлонг нь ойлгуулъя гэвэл зөвшөөрөх үү, та нар.

### Бат:

Хотын захад, уул, усандаа ойрхон агаар сайтай газар шинэ эмнэлэг барьмаар байна.

### Уншигч:

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүд арай дэндэж байна аа. 11.00 цаг хүртэл ажиллаад л цайны цаг дуустал алга болчихож байна. Өвчтнүүд нь үүдэнд нь хүлээгээд, хүлээгээд ирэхгүй, семинар, сургалтад суулаа гээд алга болж байна. Жирэмсэн эхчүүдээс шинжилгээ авах гэж бөөн дарамт, хүнд суртал гаргаж байна. Үүдэндээ сандал ч тавиагүй юм байж хөл хүндтэй эхчүүдийг удаан хугацаагаар агааргүй, муухай орчинд зогсоож, “шийтгэж” байгааг юу гэж ойлгох вэ.

**Гэрэл:**

Үнэн зүйл бичжээ. Саяхан манай ажлын хүн хатгаа аваад эмнэлэгт хэвтэж байхад нь ханиадаар дөрвөн хүн нас барсан байна. Энэ чинь одоо юу болоод байна вэ. Ханиад аминд хүрэх өвчин мөн үү. Үүнийг мэдэж, анхаарч байгаа газар хаана байна аа. Олон жил эрүүл мэндийн даатгал төлсөн атлаа шаардлагатай эмчилгээгээ авч чадахгүй захын өвчнөөр үхэх нь юуны цондон бэ. Анхаарах цаг нэгэнт болжээ. Үүнд зөвхөн эрүүл мэндийн салбарынхан бус ард иргэд ч анхаарлаа хандуулах цаг нь иржээ. Аль ч эмнэлэг тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийх цаг нь ирсэн. Дээрээс нь сургалтын арга барилыг яаралтай шинэчлэх хэрэгтэй. Одоогийн сургалтын систем Монголын хөрсөнд суухгүй, дэмий сургалт болоод таарч байна. Сургалтын системийг үндсээр нь өөрчлөхгүй бол энэ байдал олон жил үргэлжилнэ.

**Баяр:**

Үнэн шүү. Манай эмч, сувилагч нар үнэхээр хүнтэй харилцаж чадахгүй, хялалзаж, цэхэлзсэн, хүн загнасан хүмүүс байдаг. Ялангуяа улсын эмнэлгийн эмч, сувилагч, ажилтнууд. Мөнгөтэй, авлига өгсөн хүмүүсийн улыг долоочих гээд андашгүй, хэлж ярьж байгаа нь хүртэл тэс ондоо болчихдог. Энэ бол Монголын эмгэнэл.

**Туяа:**

Үнэхээр үнэн зүйл бичжээ. Монгол эмч нарын харилцаа, ёс зүйг солонгос эмч нарынхтай харьцуулшгүй. Монгол эмч нар бухимдалтай, цалингаа амьдралдаа хүргэхийн төлөө толгойгоо ажиллуулж байна. Хамгийн хүнд, хэцүү мэргэжлийг эмч, эмнэлгийн салбарынх гэдгийг ард түмэн мэднэ. Тийм ч учраас эрүүл мэндийн салбарыг сайжруулах, шинэчлэхийн тулд цалинг нь нэмэхэд хэн ч барьцахгүй гэж бодож байна, төсөв батлагчид аа. Цалин сайн өгч байж өндөр хариуцлага нэхнэ шүү дээ.

**Судлаач:**

Энэ байдлыг зөвхөн цалинтай холбож ярих нь буруу. Цалин багатай болохоор мэдлэггүй, чадваргүй, хүйтэн, хөндий байдаг юм биш. Хамгийн гол нь бэлэнчлэх сэтгэлгээ, эзэмшсэн мэргэжлийнхээ эзэн нь болж чадахгүй байгаад бүх учир байна.

**Болор:**

Гол нь манайд эмнэлэг хүрэлцээгүй, өөр нийгмийн тогтолцоонд шилжээд 20 гаруй жил болоход өмнөх нийгмийн үеийн орон тоо, ор, эмнэлгийн байгууллагын барилга нэмэгдээгүй. Гэтэл улсын маань хүн ам өссөөр л байна. Төр засгийнхан маань өөрчлөгдөж Черчиль төстэй томчуудын тоо өсөж, тансаг зэргийн хаус, унаа, албан өрөө нь дэлхийн жишгээс давах гэж улайрсан хүмүүсийг олж харж байгаагаас улс орны хүн ам зүйн бодлого царцанги байсаар 20 жилийг ардаа үдлээ. Хэдхэн цөөн орон тоо нь толгой хоосон ихэрхэх зан үйлд түлхүү хүмүүжсэн цөөн тооны хүмүүсийн дураараа дургиж дунд чөмгөөр жиргэх суудал болж хувирсан. ЭМШУИС сургалт гэж юу ч үгүй алхам бүр нь мөнгөөр шийдэгдсэн. Төгсөөд ажлын байрны төлөө алалцаан болдог ийм л сургууль болж өөрчлөгдсөн. Төгсөгчид нь эмчлэх эрхгүй. Түүнийгээ мөнгө төлж авна. Ийм байхад хөгжил хол байна даа.

**Уншигч:**

Миний бие мөнгөтэйдээ биш зайлшгүй шаардлагатай учраас гадаадад хагалгаа хийлгээд ирлээ. Манай эмч нар хариуцлагагүй байна. Өнгөрсөн хавар Гэмтлийн эмнэлэгт хүнд хагалгаанд орсон боловч, хагалгаа амжилтгүй болж, Солонгос явахаас өөр аргагүй болсон. Үнэхээр эмч, сувилагчдын харилцаа, үйлчилгээ тэнгэр, газар шиг ялгаатай, техник, технологийн шинэчлэл манайд үнэхээр шаардагдаж байна.

**Уншигч:**

Хувийн эмнэлгийг дэмжих хэрэгтэй. Төрийн хүнд суртлаас хөгжил хүлээх хэрэггүй. Учир нь олон жил төрийн эмнэлгүүдтэй зууралдаад тусыг олсонгүй. Одоо өрсөлдөөн, өөрчлөлт, шинэчлэл хэрэгтэй байна.



## УИХ-ын гишүүд шинэ жилийн дурсамжаа задаллаа

Өвлийн өвгөн аав, цасан охин, гацуур модтой шинэ жил айл бүрийн хаалгыг тогшиж, аз жаргалтай амьдралын үүдийг нээхээр ирж байна. Манай баярын дугаарт УИХ-ын гишүүд шинэ жилийн сэтгэлд хоногшсон дурсамжаа хуучилж байна. Улиран одож буй 2012 оны УИХ-ын ээлжит сонгуульд олны итгэлийг хүлээж, төрийг түшилцэж яваа түшээдийн шинэ жилийн дурсамж бид бүхний баярыг хачирлах биз ээ.

## Сумын төвийн шинэ жил анх удаа үзэх гэж хөөр болж билээ

### Н.Батцэрэг /УИХ-ын гишүүн/

-Шинэ жил гаднын соёл боловч манайд аль хэдийнэ “нутагшсан”. Тиймээс шинэ жил ойртоод ирэхээр вальсийн аялгуу, бие биедээ аз жаргал хүссэн ерөөлийн үгс, өвлийн өвгөн аав, цасан охин, бэлэг хамгийн түрүүнд санаанд бууна. Бага байхад шинэ жил дандаа гэгээн дурсамж үлдээдэг. Шинэ жилээр өвлийн өвгөн ааваас бэлэг авна. Тухайн үед болдог байсан онцчуудын шинэ жилд оролцоно. Шинэ жилийг их хүлээдэг байлаа. Миний санаанд тод үлдсэн шинэ жил бий. Тухайн үед өвлийн амралт болж байсан. Сумын төвд шинэ жил үзэх гэж яваад амжихгүй морин дэл дээр шинэ оноо угтаж билээ. Хамаатны ахтай хамт явсан болохоор айл хотлоор орж, замдаа нэлээд саатсан. Сумын төвийн шинэ жил анх удаа үзэх гэж явсан минь энэ л дээ. Их баяртай хүн явж байлаа. Гэтэл шинэ жил өнгөрсөн хойно сумын төвд ирж байв.



## Нандин

### М.Зоригт /УИХ-ын гишүүн/

-Шинэ жил гэхээр надад гэр бүлийн халуун, дотно уур амьсгал санаанд буудаг. Тиймээс шинэ жилийг гэр бүлийн баяр гэж боддог. Гэр бүлээрээ сайхан амттай хоол, унд бэлтгээд ширээ тойроод суух аз жаргал. Хүн чинь гэртээ гоё ганган байдаггүй шүү дээ. Бие биедээ таалагдах гэж гоё хувцас ч өмсөөд байдаггүй. Харин шинэ жилээр бол хамгийн гоё хувцсаа өмсөж, бие биедээ бэлдсэн бэлгээ задална. Шинэ жил бол гэр бүлийн баяр. Нэг дурсамжтай шинэ жилийг би мартдаггүй. Их олон жилийн өмнө болсон. Тухайн үед чихэр, жимс ховор байсан. Тэр үед шинэ жил дөхүүлээд төрөөс албан ёсоор мандарин, алим гаднаас оруулж ирдэг байсан. Алим, мандарины үнэрээр шинэ жил мэдрэгддэг. Алим, мандарин үнэтэй байсан. Тиймээс ээж, эмээ хоёроос нууцаар ажил дээрээ биднийг дүү нарын хамт аваачиж, алим жимсээр дайлдаг байлаа. Манай эмээ аав хоёр ээжийг үргүй зардал гаргалаа гэж зэмлэдэг байж л дээ. Дүү нартайгаа алим, мандаринаа идэж дуусаад шууд харихгүй. Мандарин чинь хурц үнэртэй. Очих юм бол эмээ мэдчихнэ. Тэгээд лав хоёр цаг гаруй гадуур алхаж, тоглож байгаад гэртээ орно. Энэ үеийн шинэ жил надад хамгийн нандин санагддаг.



## Ухаан орсон цагаас хойших бүхий л шинэ жил сайхан

### Ч.Эрдэнэчимэг /УИХ-ын гишүүн/

-Цагаан сар гэр бүлийн баяр. Харин шинэ жил хамт олон, залуу хүмүүсийн хувьд хамгийн сайхан баяр гэж боддог. Найз нөхөдтэйгээ уулзана. Эмэгтэй хүний хувьд хамгийн сайхан хувцсаа жилдээ нэг удаа өмсөнө. Бусдад гоё гэдгээ харуулна. Шинэ жил бол залуу сэтгэлгээтэй баяр. Тиймээс залуучууд илүү хүсэн хүлээдэг байх. Ухаан орсон цагаас хойших бүхий л шинэ жил сайхан. Хүүхэд байхдаа онц сурч, Өвлийн өвгөн ааваас бэлэг авдаг байлаа. Энэ л хамгийн гоё дурсамж юм уу даа.



## Хөтлөгч хийж байлаа

### Ц.Цолмон /УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга/

-Шинэ жил бүхэн өөр өөр дурсамжтай байдаг. Миний хувьд өөрөө оролцож, зохион байгуулж байсан шинэ жил илүү дотно, сэтгэлд ойрхон. Сурагч байх үеийн шинэ жил сэтгэлд хоногшиж үлдсэн, хамгийн сайхан баяр байдаг. Өөрсдөө шинэ жилээ тэмдэглэнэ, хөгжилдөнө. Хамгийн сүүлд Гадаад харилцааны яамны дэд сайд байхдаа архангайчуудын шинэ жилийг зохион байгуулж, хөтлөгч хийж байлаа.



## Өвлийн өвгөн ааваас бэлэг авч байсан үеэ хэзээ ч мартдаггүй

### С.Ганбаатар /УИХ-ын гишүүн/

-Шинэ жил бүхэн сайхан. Миний хувьд 1982 онд дөрөвдүгээр ангидаа 75 хувийн онц дүнтэй гарч, Дархан-Уул аймгийн Дарханы есдүгээр сургуулийн өвлийн өвгөн ааваас бэлэг авч байсан. Үүнийг хэзээ ч мартдаггүй.



## Шинэ жил бүхэн онцгой

### Ж.Эрдэнэбат /УИХ-ын гишүүн/

-Хүн бүхний хүсэн хүлээдэг баярын нэг бол шинэ жил. Шинэ жил бүхэн онцгой. Бид чинь шинэ жилдээ гоё, ганган байхаас гадна байгаль, дэлхийгээ чимэглэж, сүлд модоо засдаг. Шинэ жилийн арга хэмжээ бол өнгөлөг, цоглог хамгийн сайхан ая эгшигтэй. Тиймээс байгаль, дэлхий ч мөн адил үзэсгэлэнтэй болдог. Шинэ жилийг гэр бүлийнхэнтэйгээ тэмдэглэдэг.



ТОМИЛОЛТ

# ТӨР МИНЬ “ТОГТОЖ” ХАЙРЛА

Б. ҮҮРИЙНТУЯА

...Дэвшихэд хэрэгтэй хөрөнгө, мөнгө чинь үүд тогшиж байхад хаалгаа нээх гэж хугацаа бүү алд...



Фотог Э.Зоригт

Бизнес гэгч “буцалж” байдаг дэлхийн хотуудын нэг бол Дорнын сувд гэгдэх Шанхай. Брэнд цамцны энгэрийг тамгалах өнгө өнгийн зангиа зүүсэн залуус, дэгжин даашинзаар гоёж, “Starbucks”-ын кофе, гангархал дэгжирхэл Шанхай хотын гудамжийг чимнэ. Эзэн Чингисийн үед тосгон төдий байсан гэгдэх эл хот өдгөө олон улсын бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын хоёр дахь гэр болон хөгжжээ. Дэлхийн эдийн засгийн төвүүдийн хүндэт зочноор тодроод буй Монгол Улс тэнгэр өөд тэмүүлэх цамхагуудын хурлын зааланд алдраа цуурайтуулах нь тэр ертөнцийн нэгээхэн хэсэг болсныг гэрчлэх.

Үзэсгэлэнт Хуанпу голын бадамлянхуа нь болсон Шанхай хотноо энэ сарын 10-12-нд “Монголын хөрөнгө оруулалт, Цэвэр нүүрсний Азийн дээд

хэмээний чуулга уулзалт 2012” хоёр дахь удаагаа зохион байгуулагдсан билээ. Мэдээллийн ивээн тэтгэгчээр ажилласан “Mongolian Economy” сэтгүүлийн сурвалжлах баг тус чуулганы мэдээ, сурвалжлагыг цахим хуудаастаа онцолж байсныг та бүхэн уншсан биз ээ. Цас, мөсний улирлаас түр ч атугай холдож, зөөлөн салхиар илбэх харийн орны хөх тэнгэр дор эх нутгийн минь тухай хэрхэн ярихыг сонсон суухад сэтгэл бахдаж бас гонсойж байлаа.

## Хөгжилд хөтлүүлэхсэн...

Нүүрсний батлагдсан нөөцөөр дэлхийд 15 дугаарт жагсах Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн гол хүч нь уул уурхай. Энэ салбараа дэлхийн тавцанд гаргахаар монголчууд ханцуй шамлан ажиллаж байна. Гэвч бидэнд

маш их хөрөнгө оруулалт хэрэгтэй. Үүнийг ч холбогдох албад төдийгүй төр, засаг онцолсоор ирсэн. Чухам яг энэ асуудлаар чуулганы эхний өдөр гадаад, дотоодын төлөөлөгч, оролцогчид хэлэлцэх учиртай байв. “INBC Global”-ын зохион байгуулсан тус чуулганд манай талаас зарим холбогдох газрууд хамтран ажиллах байсан ч Монголоос гарын арав битий хэл таван хуруу ч ихдэхээр тооны төлөөлөгч оролцсон нь сэтгэл гонсойлгож байсан юм. Сайхан үг сэтгэл татах ч саар үйл түүнийг мохооно гэдэг энэ байх.

Монголын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хандлага, хууль эрх зүйн орчныг сонирхсон гадаадын төлөөлөгчид хурлын заалыг дүүргэхийн сацуу хүлээлт тээсэн асуултын хариуг олох найдлага өвөртлөн ирсэн байлаа. Чуулганы салхийг хагалан Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд асан Д.Зоригт хурлын цөм болсон Монголын эдийн засгийн хэтийн төлөв, байгалийн баялаг, эрчим хүчний нөөц зэрэг өргөн хүрээг хамарсан илтгэл тавьсан. Түүний үгс Монгол Улсыг хөрөнгө оруулалтын гол цөм хэмээн итгэж буй хөрөнгө оруулагчдын сэтгэлд оч бадраах шиг. Гэвч үйлдлээр биш, үгээр аливааг хэрэгжүүлэх хүсэлтэй монгол зан хөрөнгө оруулагчдыг үргээх хамгийн том асуудал болохыг “PricewaterhouseCoopers” аудитын Хөрөнгийн зах зээл, арилжааны лидер Жоанна Кейв удаах илтгэлд дурдсан. Тэрбээр “Монголд уул уурхайгаас гадна санхүүжүүлэх боломжтой олон салбар бий. Өнгөрсөн онд хөрөнгө оруулагчид Монгол Улс руу “шуурч” байсан. Энэ жил ялимгүй буурсан. Үүнийг зөвхөн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн асуудалтай холбоотой гэвэл хэт өрөөсгөл болно. Хөрөнгө оруулалт татахад хууль эрх зүй, улс төрийн тогтвортой байдлаас гадна түншийн ▶

▶ итгэлцэл чухал” хэмээн манай сурвалжлах багийнханд учирласан юм.

Өнгөрсөн онд ДНБ-ий өсөлтөөрөө олны атаархлыг төрүүлж чадсан Монгол Улс энэ онд амжилтаа эвдэж чадсангүй. Тархи царцам хүйтэн өвлийг угтаж Монгол дахь хөрөнгө оруулалт хөрж эхэлсэн. Гаднынхан манай орны их баялагт мөнгөө харамгүй зарах хүсэлтэй байгаа ч дулаарахыг хүлээж суух цаг үгүйг чуулга уулзалтын үеэр олон улсын хөрөнгө оруулалт, бизнесийн салбарынхан сануулж байлаа. Гэсэн ч Монгол орон тэдний хайрыг татаж, хэтэвчийг нимгэлсээр байх тухай чуулганд оролцогчид дуу нэгтэй хэлж байсан юм. Хэдий тийм ч санаа амрах болоогүй.

“Монгол Улсын хууль, эрх зүй, татварын орчин ба түүний хязгаарлагдмал байдал” сэдвээр илтгэсэн “Anderson & Anderson” хуулийн фирмийн Шанхай дахь салбарын ахлах түнш Давид Баксбам “Бид Монголын эрчим хүчний нөөц хийгээд монголчуудын санаа, бодлыг сонирхож байна. Би Монголын тухай нэлээд ихийг мэдэх ч суралцах зүйлс гарч ирсээр байгаа. Үүний нэг нь хөрөнгө оруулалт, түүний тухай хууль. Энэ талаар санал, бодлоо хуваалцах боломж өгч буй тус хурлын зохион байгуулагчид болон мэдээллийг түгээхээр ирсэн танай хамт олонд талархаж байна” гэсэн юм. Мөн тэрбээр “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Учир нь тэдгээр заалт нь олон улсын зарим гэрээг зөрчиж байгаа юм. Энэ талаар Монголын Загсийн газрын төлөөлөгч нартай уулзсан. Хуулийн асуудал ундарсан хэвээр байгаа тул хөрөнгө оруулагчдын хувьд хүлээлтийн байдал үүссэн төдийгүй тэд эргэлзэж эхэлсэн ч сонирхол нь буураагүй. Харин үүнийг идэвхжүүлэх нь Монголын Засгийн газрын үүрэг” хэмээн учирласан билээ.

## Хар алт “халагдах” болоогүй

Мөнгө хэрэгтэй ч ямар аргаар түүнийг олох вэ гэдгээ анхлан бодох нь амжилтын эхлэл гэлтэй. Ийм эхлэлийг Монгол нүүрсний арвин нөөцөөрөө хэдийнээ тавьчихсан. Түүрүү онд Монголын экспортын 40

гаруй хувийг бүрдүүлсэн 21.1 сая тонн нүүрсний дийлэнх хувийг урд хөршдөө нийлүүлжээ. Сүүлийн гурван жилд хар алтны экспорт 10 хүртэлх сая тонноор нэмэгдсэн гэх албаны мэдээлэл байгаа бол эл тоо 900 мянган тонноор нэмэгдэх тооцоог энэ онд гаргасан байна. Хятадын коксжих нүүрсний ассоциацийн ерөнхийлөгч “Манай ассоциациас гаргасан статистикаас харвал 2011 оны эхний найман сард Хятад 26.49 сая тонн коксжих нүүрс импортолсны 43 хувийг нь Монголоос авсан. Харин уул уурхайн томоохон төлөөлөгч Австрали улсаас ердөө 21 хувийг импортолсон нь Монгол Улс Хятадын хамгийн том нүүрс нийлүүлэгч болсныг нотолж байна” хэмээсэн байдаг.

Нүүрсний “хаанчлалд” захирагдах дэлхийн эрчим хүчний салбар “ногоон” болохыг зорьж буй өнөө үед Монгол олон улстай хөл нийлүүлэн алхах хэрэгтэйг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд асан Д.Зоригт хэлсэн. Тиймээс дээрх хурлын үеэр зах зээлийн эрэлт бага, хямд өртөгтэй хүрэн нүүрсийг үнэд хүргэх технологийн талаар олон улсын 20-иод компанийн төлөөлөгч хоёр өдөр чуулсан юм. Хүрэн нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх туршилтыг амжилттай хийж өдгөө үйлдвэрлэлийн гараагаа эхэлсэн Япон, Австрали болон Хятадын томоохон компаниудын төлөөлөгчид өөрсдийн төсөл, бүтээгдэхүүний талаар цугласан олонд танилцуулахын зэрэгцээ туршлага солилцож байлаа.

“Fischer-Tropsch” технологийн тусламжтайгаар нүүрс шингэрүүлэх технологийг нэвтрүүлээд хагас зууныг илээсэн Өмнөд Африкийг төлөөлөн “Clean coal technology” компанийн гүйцэтгэх захирал, доктор Лин Ту “Цэвэр нүүрсний технологийг дэлхий нийт сонирхож байна. Цаг уурын өөрчлөлт, эрчим хүчний хомсдол гээд олон асуудал үүнийг эрэлттэй болгож байгааг онцлох хэрэгтэй. Энэ шаардлагын дагуу эрчим хүчний импортоос хамааралтай улсууд өөрт байгаа нөөцөө ашиглан дотоодоо хангах, цаашдаа дэлхийн зах зээлд нийлүүлэх боломжуудыг эрэлхийлэх нь зүйтэй” гэв. Тэрбээр “Нүүрсний хэрэглээг байгаль, орчинд ээлтэй болгох ажлыг эхлүүлээд багагүй

хугацаа өнгөрсөн. Харин сүүлийн хэдэн жил шинжлэх ухааны үндэстэйгээр нэвтрүүлж, үйлдвэрлэл явуулах тухай ярих боллоо. Цөөнгүй оронд туршилт төдий байгаа ч бүтэхгүй зүйл хэмээх нь учир дутагдалтай. Асар их судалгаа, туршилтын үндсэн дээр гарсан эерэг санааг няцаах биш дэмжиж байж амьдралын хөрсөнд бууна” гэсэн юм.

Нүүрс шингэрүүлэх үйлдвэр барих цөөнгүй төсөл манайд хэрэгжихээр байгаа. Гэтэл мэдэхгүй өнгөрөөв үү, тоолгүй үлдээв үү гэдгийг хэлээд өгөх элэг нэгтэн ховор үзэгдэнэ, эл уулзалтад. Уг нь олон улсын хурал, цуглаанд жижиг гэлтгүй оролцож, туршлага судлах нь манай улсын эдийн засгийн хөшүүрэг болж буй уул уурхайн салбарынханд хэрэгтэй баймаар. Энэ талаар эдийн засагч Д. Жаргалсайхан “Нүүрс бол манай улсын эдийн засгийн томоохон хөдөлгөгч хүч. Гол шалтгаан нь манай урд хөршийн хэрэгцээ. Энэ хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд гарч буй өөрчлөлтүүд монголчуудын мэдэж, урьдчилан харж чадах ёстой хүчин зүйлсийн нэг. Тийм учраас энэ төрлийн, ялангуяа нүүрсний салбарт ашиглалт, олборлолт, боловсруулалтад дэлхийн хэмжээнд яригдаж буй асуудлууд бидний хувьд амин чухал” гэв. Түүний хэлснээр эрэлтийн түвшин, өгөөжөөс шалтгаалах үр нөлөө манай улсын үйлдвэрлэл, экспортод онцгой үүрэгтэй. Их нөөцөө ямар технологиор эргэлтэд оруулах, улмаар эрчим хүчний хэрэгцээгээ хангах, цаашлаад нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх технологийг мэдэх, ойлгох, судлах нь чухал аж.

Ам алдвал буцааж болдоггүй. Хэлсэн үгээ хэдэнтээ няцаах нь Монголын эдийн засаг, ирээдүй хойчийн хөгжилд тушаа болж буйг мэдсээр атлаа харж суух төр минь “тогтож” хайрла. Дэвшихэд хэрэгтэй хөрөнгө, мөнгө чинь үүд тогшиж байхад хаалгаа нээх гэж хугацаа бүү алд. Тэд биднээс итгэж болох тогтвортой байдлыг л хүсэж байна.

Ийнхүү ховор үзэгдэх Шанхайн цэлмэг тэнгэр дор гурван өдөр үргэлжилсэн чуулга уулзалт өндөрлөсөн юм. Ээх нартай “мишээн” угтсан Дорнын сувд гунигийн нулимс дусаав уу гэлтэй шиврээ бороогоор зочдынхоо аян замд цацал өргөсөн билээ. ■

ЭЛЧИН САЙД

# НОГООН ӨСӨЛТИЙГ БҮТЭЭЭ

Х.ХУЛАН

*Кристофер Чарльз Стюарт нь Их Британиас Монгол Улсад суух Цогжавхлант Хатан хааны Элчин сайдаар томилогдсон билээ. Энэхүү үүрэгт ажлаа 2012 оны тавдугаар сард хүлээж авсан. Кристофер 1997 онд Их Британийн Гадаад харилцаа, хамтын нөхөрлөлийн газар анх оржээ. Мөн Токиод Шинжлэх ухаан, технологи хариуцсан даргаар, Осакад Ерөнхий консул, Их Британийн Худалдаа, хөрөнгө оруулалтын газрын (УКТИ) тэргүүнээр ажилласан байна. Элчин сайдаар томилогдох хүртлээ “Эрчим хүч, технологийн институт”-д Корпорацийн хөгжлийн хэлтсийн захирлын албыг хашиж байсан туршлагатай.*



ФОТОГ Э.ЗОРИГТ

**-Монголын тухай Таны бодлоор ярилцлагаа эхлүүлье?**

-Өмнө нь Монголд хоёр ч удаа ирж байсан. 2000 оны зун, дараа жил нь гурван долоо хоногийн хугацаатай ирсэн. Энэхүү айлчлалын үеэр төрсөн Монголын тухай сэтгэгдэл намайг дахин энд ирж ажиллахад хүргэсэн юм. Миний өмнө нь харж байсан бүхнээс маш их ялгаатай байсан. Сонирхолтой, сэтгэл татам, үзэсгэлэнтэй. Зун ирсэн болоод ч тэр үү үнэхээр сайхан санагдсан.

**-Та манай өвөлд хэр дасаж байна вэ?**

-Эндхийн өвөл миний төсөөлж байснаас дажгүй юм. Хэм нь хэдийгээр доогуур зааж байвч их хуурай. Гэтэл Их Британид танай өвөг шиг хүйтэрдэггүй боловч 15 хэмээс буурахаар маш чийглэг, жихүүн болдог. Монголын цаг агаар надад таалагдаж байна.

**-Улаанбаатар өвөл болохоор утаатай тэмцэж эхэлдэг. Олон жилийн өмнө Лондон хот ч ийм асуудалтай тулгарч байсан. Агаарын**

**бохирдлоо яаж арилгаж чадсан бэ?**

-Лондон хот Хатан хаан Викториягийн үеэс утааны бэрхшээлтэй тулгарсан. Аж үйлдвэржилт, хатуу түлш мөн энэхүү асуудлын нэг хэсэг нь байв. Лондон үүнийг өөрчлөх хэрэгтэй гэдгийг ухаарсан. Тэгэхийн тулд нүүрсийг задгай гал дээр шатаахыг хориглож, утаагүй бүс болгосон туршлагатай. Утаагүй түлшний хэрэглээг нэвтрүүлсэн нь аажмаар утаа болон үүнээс үүдэн гарах эрүүл мэндийн асуудлыг (Монголд өнөөдөр ►►

▶ тулгарч буй асуудалтай адил) шийдсэн юм.

**-Агаарын бохирдлыг бууруулахын тулд ямар арга хэмжээ авч болох вэ?**

-Энэ чиглэлээр танай улс олон үйл ажиллагаа явуулж байгаа юм байна лээ. Хотын задгай зууханд зориулж утаагүй түлш үйлдвэрлэх хүсэлтэй хэд хэдэн байгууллагатай танилцсан. Гэхдээ утаагүй түлш агаарын бохирдлыг шийдэх цорын ганц арга биш. Эрчим хүчний эх үүсвэр өөрчлөгдөх нь цахилгаан хэрэглэдэг болгох магадлалтай. Хүмүүс хатуу түлшээр галладаг байр, сууцнаасаа нүүж, цахилгаанд тулгуурласан халаалтын хэрэглээнд шилжсэн тохиолдолд хатуу түлш нь эрчим хүчний эх үүсвэрийн тооноос хасагдана. Цэвэр нүүрсний дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн цахилгаан станцуудыг ажиллуулах нь утааны үр нөлөөг бууруулна. Их Британид 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтыг 80 хувиар бууруулах зорилго дэвшүүлсэн бөгөөд үүний тулд цахилгаан халаалтыг түлхүү ашиглах бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

**-Эдийн засгийн хямралын үеэр Элчин сайдаар томилогдсоны хувьд өнөөгийн нөхцөл байдлын талаар юу хэлэх вэ?**

-Мэдээж дэлхийн ихэнх улс эдийн засгаа өсөлттэй байлгах сонирхолтой байдаг. Эдийн засгийн өндөр өсөлт давуу тал авчирдаг ч үр ашгаа зохистой хуваарилж, улс орноо бүхэлд нь хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Үүний тулд олон асуудлыг цогцоор нь авч үзэх хэрэгтэй тул эгзэгтэй байдаг. Гэсэн ч олон орны даван туулсан сайн, муу туршлагатай танилцаж, тэднээс суралцах боломжийг бүрдүүлж байна.

**-Их Британи, Монгол Улс хоёрын гадаад харилцаа, худалдааны түншлэлийн талаар Та юу хэлэх вэ?**

-Ирэх жил хоёр орны дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн баярыг тэмдэглэнэ. Иймд, 2013 оны турш олон төрлийн арга хэмжээ, үйл явдлыг Их Британи болон Монголд зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа. Манай хоёр улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбар хоорондын харилцаа холбоогоо улам бататган бэхжүүлэхийн төлөө

хамтарч ажилладгийг дурдахад таатай байна. Саяхан Монголын эрүүл мэндийн тогтолцоотой танилцахаар Их Британиас төлөөлөгчид хүрэлцэн ирсэн. Ирэх оны эхээр Монголын төлөөлөгчид манай улсад айлчилж, хоёр орны хамтын ажиллагааны бололцоог тогтоож, эдгээрийг хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэх юм. Түүнчлэн хамгийн сүүлд Монгол- Их Британийн дугуй ширээний уулзалтыг Лондон хотод зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний үеэр боловсрол, санхүү, дэд бүтэц, ногоон технологи, зам, төмөр зам, эмнэлэг, сургууль, хот төлөвлөлтийг багтаасан олон салбарын хамтын ажиллагааны тухай ярилцсан.

**-Их Британи улс ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд ихээхэн идэвх, зүтгэл гаргаж ирсэн орнуудын нэг. Монголд ногоон өсөлтийг хөгжүүлэх тал дээр Та ямар зөвлөгөө өгөх вэ?**

-Монгол Улсад хөгжлийнхөө гарааны үе шатандаа ногоон технологийг нэвтрүүлэх завшаан тохиожээ. Өнөөдөр энэ чиглэлээр хэрэгжиж буй санаачилга, төслүүдийг хараад надад өндөр сэтгэгдэл төрсөн. Жишээлбэл, өнгөрсөн зун би Монголын анхны салхин паркттай танилцсан. Эдгээр санаачилга нүүрстөрөгчийн хэмжээг бууруулахад ач холбогдолтой. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчний салбар нь ногоон ажлын байр бий болгохоос гадна уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалахад хувь нэмрээ оруулдаг.

“Азийн эрчим хүчний супер сүлжээ”-г хөгжүүлснээр бүсийн бусад оронд цэвэр эрчим хүч экспортолж, Монголын эдийн засгийг сайжруулах боломжтой гэж үзэж байна. Ногоон өсөлтийн олон эерэг үйл ажиллагаа явагдаж байна. Эдгээрийг дагаад уул уурхайгаас хараат бус, тэнцвэртэй эдийн засаг бүрэлдэн бий болгох бүрэн боломж байна.

**-Та тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс хувийн хэвшлийн салбарт ажилласан туршлагаасаа харахад түүний үндсэн элементүүдийг хэрхэн тодорхойлох вэ?**

-Их Британийн Засгийн газрыг 2050 он гэхэд нүүрстөрөгчийн давхар ислийг 80 хувиар бууруулах



Эх сурвалж: Der Fischer Weltatmanach

зорилгод хүргэхийн тулд технологи боловсруулдаг эрчим хүчний байгууллагад би ажиллаж байсан. Английн эрчим хүчний эх үүсвэрт дүн шинжилгээ хийснээр бид технологийн хоцрогдлыг илрүүлж, үүнийгээ сайжруулах шаардлагатайг олж харсан. Үүний тулд том хэмжээний техник, технологийг нэвтрүүлсэн. Төрөл бүрийн далайн эргийн салхи, ухаалаг систем, түрлэг болон халаалтын технологи үр ашгийг нэмэгдүүлж, зардал бууруулан эрчим хүчний ногоон шийдэл олоход тусалсан юм. Тогтвортой байдал гэдэг нь зөвхөн эрчим хүчний асуудал биш, харин ажиллах амьдрах орчиндоо шинэ технологийн хэрэглээг нэвтрүүлэх, дэд бүтцийн хөгжил, байгалийн баялгийн ашиглалт, хог хаягдлын менежмент, үр ашигтай үйлдвэрлэл, тогтвортой өсөлтийг байгаль орчныг сүйтгэлгүйгээр, мөн амьдралын стандартыг цаашид ч гэсэн дэмжихийг хэлнэ. Энэ бүх салбарт Монгол Улс ногоон өсөлтийг оруулах боломжтой байна.

**-Их Британи улс манай уул уурхайн салбарын зөв хөгжилд хэрхэн тусалж чадах вэ?**

-Манай улс уул уурхайн салбарын арвин туршлагатай. Дэлхийн хэмжээнд олон компани үйл ажиллагаа явуулж байгаа. Одоогоос 40-өөд жилийн өмнө Их Британи нүүрсний уурхайн аж үйлдвэрийг хөгжүүлж эхэлснээр уул уурхайн салбар ил тод байдал, байгаль орчны асуудлыг зохистойгоор шийдэж өгч чадсан. Хариуцлагатай уул уурхайн ▶



► бодлогод хор уршигтай үр нөлөөллийг хамгийн бага байлгаж, уул уурхайн үйл ажиллагаа дууссан үед, мөн нөхөн сэргээлт хийх нь тогтвортой байдал.

Оюутолгойг Англи-Австралийн хамтарсан “Рио Тинто” компани удирддаг. Түүнчлэн Монголд уул уурхайг хөгжүүлэх боломжийг хайсан бусад томоохон уул уурхайн төслүүд шатандаа явж байна.

**-Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар таны бодлыг сонирхож болох уу?**

-Уг асуудлыг гэрээний үндсэн зорилго, агуулгыг хадгалахын зэрэгцээ Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтын өсөлтийг хөхиүлэн дэмжихүйц байдлаар шийдвэрлэх ёстой гэдгийг Засгийн газар, Оюутолгой аль аль нь ойлгож байгаа гэж би бодож байна. Энэ тохиолдолд талуудын аль алины хувьд ашигтай байх болно.

**-Та Японд ажиллаж, амьдарч байсан тухай ярьж өгнө үү?**

-Би Японд 12 жил амьдарсан. Үүнээс зургаан жил нь Токиод амьдарч, шинжлэх ухаан, технологи хариуцан ажилладаг байсан. Монголын шинжлэх ухааны салбарыг ойрын хугацаанд сайтар судлахаар төлөвлөж байна. Ирэх онд болох 50 жилийн ойн баярын арга хэмжээгээр Их Британиас эрдэмтдийг урьж, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бололцоог судлах болно. Удаах зургаан жилд Осака хотод Ерөнхий консулын албыг хааж өнгөрүүлсэн. Тэрхүү ажил маань одоо Монголд хийж байгаа ажилтай төстэй. Гэхдээ худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлийг голлодог байсан. Монгол Улсад гүйцэтгэж буй улс төр, эдийн засгийн ажил өндөр ач холбогдолтой бөгөөд энэ үүргээ гүйцэтгэхдээ би туйлын баяртай байна.

**-Та манай хөдөө орон нутгаар явж амжсан уу?**

-Гэр бүлийнхээ хамт Өмнөговьор гайхалтай аялал хийсэн. Танай нутгийн уудам цэлгэр тал үнэхээр сүрдмээр бөгөөд солигдон өөрчлөгдөх байгалийн төрх, ургамал амьтан сэтгэл хөдөлгөм санагдсан. Элсэн манхан үзэж, эртний үүсэлтэй чулуун тогтоцыг биширч явсан тэр аяллаа хэзээ ч мартаггүй гэдэгтээ итгэлтэй байна.

Харин миний сэтгэлийг нэг зүйл гонсойлгосон. Би нэлээд олон зэрлэг амьтантай таарах байх гэж бодож байсан. Хамт аялсан монгол геологич маань 20 жилийн өмнө Өмнөговьд ажиллаж байсан. Тэрбээр тэр үед бидний аялж байсан газарт маш олон зээр байсан гэж хэлсэн. Харамсалтай нь бид гуравхан зээр олж харсан. Говиор аялсныхаа дараа Хархорин, Цэцэрлэг, Цагаан нуурын нутгаар тойрон аялал хийж эртний нийслэлийн үзэсгэлэнг харж, зэрлэг амьтан, байгальтай ч танилцсан.


**-Монголын хөдөөний амьдралыг хараад ямар сэтгэгдэл төрсөн бэ?**

-Их Британи, Монгол хоёр орныг харьцуулж харах надад их сонирхолтой байсан. Би малын бэлчээр, фермээ тойруулсан хөдөөгийн гүнд төрсөн хүн. Манай мал аж ахуй суурин, газар нутаг өвс ногоогоор элбэг ч хоёр орны хөдөөгийн байдалд ижил төстэй зүйл нэлээд их байна.

Монголын сумд Английн хөдөө тосгонтой хэмжээгээрээ адил жижиг юм. Хөдөө, орон нутгаар аялах явцад гайхалтай эртний сүм дуган, үзвэрүүд үзсэн бөгөөд энэхүү аялал танай орныг улам илүү таньж, мэдье гэсэн тэмүүлэлд хүргэсэн. Цаг, зав гарвал би судалж танилцана гэж бодож байна. ■

ҮЗЭЛ БОДОЛ

# УЛСТӨРЧИЙН НЭР ХҮНДИЙН ТӨЛБӨРИЙГ АРД ТҮМЭН ХАЛААСНААСАА ТӨЛДӨГ



С.ОДОНТУЯА /УИХ-ын гишүүн, Эдийн засагч/

## Үнээний боодог

Манай Архангайд нэг айл саалийн ганц үнээгээрээ идэш хийгээд, нэг сайн цадаж аваад хүүхдүүд нь сүү тараггүй, ааруул ээдэм цагаан идээ хүнсгүй, аав нь шимийн архигүй, товчхондоо ирээдүйгүй үлдсэн гэдэг. Үнээ нь байсан бол тэр айлын амьдралыг залгуулаад байх юм. Эдийн засаг ингэж ажилладаг. Харин улстөрч бол бусдын үнээгээр боодог хийж нэр алдар олохыг хүсдэг.

Энэ жил сонгууль болсон биш талхаараа тоглодог том, жижиг улстөрчид олширлоо. Бодитой үндэслэл, тооцоо судалгаагүй, эдийн засаг эрх зүйн “ном”-гүй атлаа зөвхөн нэр хүнд олох хүслээр цээжний пангаар гөрдөгсөд телевизийн суваг нээх болгонд, сонины зай болгонд, УИХ-ын танхимд микрофон булаалдан цуурцаана. Улстөржиж болдоггүй юм бол эдийн засаг. Эдийн засаг гэдэг бол танай гэр бүлийн талхны тухай ухаан юм.

Нэр хүнд олох гэсэн ганц хүслээр улс орноо сааж амьдардаг саалийн үнээг нудрахыг санаархагсад УИХ-д олон байх юм. Манай экспортын 80 хувийг ганцхан уул уурхайн салбар нийлүүлдэг болохоор саалийн үнээ аль нь болохыг хэлүүлэлтгүй ойлгоно биз.

Гадаад орчны хувьд дэлхийн эдийн засаг саарч, АНУ-ын эдийн

засаг бүрэн сэргэж амжаагүй байхад Европ өрийн хямралд нэрвэгдлээ. Манай гол зах зээл Хятадын эдийн засгийн өсөлт гуравны нэгээр буурсан. Дотоодын эдийн засаг тэнцвэргүй эмзэг, өндөр инфляци, хөрөнгө оруулалт зогссон, зээлийн хомсдолтой, иргэд эдийн засгийн айдастай байна.

Улстөрчид элдэв мэдэгдэл бодож олж, шок хийсээр байгаад эдийн засаг хэвийн явахад хүнд боллоо. Ажил хийсэн болж харагдах, эх орондоо хайртай дүрд жүжиглэх, сонгогчдын саналыг биелүүлж, халамж үзүүлж байгаа дүр эсгэх нь хэрээс хэтэрлээ. Хавтгайрсан халамж эдийн засгийг бүрэн сүйрүүлснийг сайн мэдэж байгаа ч 21 мянгыг үргэлжлүүлэн олгохыг шаардаад байх юм. Эдийн засаг бол популизм хийдгээс өөр. Бусдад гай тарьдаггүй, тооцоо прогнозоор ажиллах хэрэгтэй.

Сонгууль дууссан,Одоо эдийн засгаа тогтворжуулъя, улстөрчид өө!

УИХ-ын гишүүн амаа шаардлагатай үед хамжих хэрэгтэй байдаг юм.

Сүртэй мэдэгдэл хийсэн эх оронч улстөрчийн нэр хүнд бүхний нүдэн дээр өсдөг нь үнэн. Харин мэдэгдлээс болж бужигнасан улстөрийг дагаад эдийн засаг донсолж, тогтворгүй болж, алсуураа юмны үнэ нэмэгдэж, ард түмэн халааснаасаа төлдөг нь үнэн. Инфляцийн бодит нөлөөлөл

бага орлоготой иргэдэд 50-60 хувь , өндөр орлоготой иргэдэд 2-3 хувь нь л байдаг гэж эдийн засагчид тооцоолжээ. Улстөрч хожиж, жирийн иргэд хохирдог. Бид хугацааны уртад илэрдэг ийм далд уялдааг тэр бүр анзаарч хардаггүй.

Хүсэл ихдэхээрээ шунал болдог. Хүний хообий, морь, мөнгө, архи, зугаа шоу, нэр хүнд гээд хэмжээ нь ихэдсэн, савандаа багтахгүй болсон тэр зүйлийг шунал гэдэг. Шунал аз жаргал авчирдаггүй. Аз жаргал гэдэг тэвчээртэй тооцоотой ухаантай хүнд л ирдэг шагнал. Ёроолгүй, дээвэр байхгүй, шуналтай хувь улстөрчийн нэр хүндийн төлбөрийг хийх гэж ард түмний халаасыг сэгсрээд байж болохгүй. Хараат бус, бие даасан хувийн хэвшил бүхий эдийн засгийг хөгжүүлэх асуудал дээр бид гацчихаад байна.

## Эдийн засаг энгийнээр

Инфляци гэдэг бол чи илүү их төлнө гэсэн үг. Халамж бол ажил хийдгээс төрийн нэрээр дээрэмдэж ажил хийдэггүйд авч өгнө гэсэн үг. “Эх оронч” гэдэг бол чиний халаасаар өөрийнхөө нэр алдрыг өсгөгч. Татвар бол танай гэрийн хоолноос аравны нэгийг авахыг хэлнэ. НӨАТ бол нэмээд авсан талхны чинь 10 хувийг хэн нэгэн авсан хэрэг. Худлаа гэвэл супермаркетаас ▶

▶ авсан талоноо сайн үзээрэй, НӨАТ суутгаагүй талон гэж байдаггүй юм. УИХ-ын гишүүн гэдэг бол чиний мөнгөөр цалинждаг, туслахуудаа ч чиний мөнгөөр цалинжуулдаг, өөрөө чиний мөнгөөр хивс дэвссэн, кофе үнэртсэн урт саруул коридортой дулаан цагаан байшинд ажилладаг, түүнийгээ чиний мөнгөөр чамаас хамгаалуулдаг. Харин оронд нь ард түмнээ хүн шиг амьдруулж, улсаа улс шиг хөгжүүлээсээ гэж биднийг сонгодог. Гэтэл тангараг өргөснөөс хойш зарим гишүүний барааг олж харсангүй. Ядаж л долоо хоногийн хоёрхон өдөр хуралддаг чуулгандаа суугаад байж болдоггүй юм болов уу. Эсвэл би шинэ гишүүн болоод учир начин, зовлонг нь ойлгохгүй байна уу.

## Тогтвортой улс орон

Тавхан тэрбум ам.долларын төсөвтэй, найман тэрбум

ам.долларын активтай банкттай, бараан захын лангууны худалдагчаас эхлээд барилгын захирал хүртэл бүгд МӨНГӨ ХҮҮЛЭГЧДЭЭС АЙЖ АМЬДАРДАГ манай багахан эдийн засгийг хөл дээр нь босгоход зөвхөн дэд бүтцийн салбарт гэхэд 24 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн дүгнэлтэд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв “МакКинзий” компанитай хамтран боловсруулсан судалгааны баг хүрчээ.

Шаардагдаж буй хөрөнгийн хомсдолыг үндэсний болон гадаадын хувийн хөрөнгө оруулагчид хангаж чадах билээ. Гэвч бид хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх учиртай суурь нөхцөлүүдээ эрсдэлд хүргэсэн алхмуудыг хийсээр байна. Бодлого зохицуулалтын ТОГТВОРТОЙ ОРЧНЫГ бий болгож, бизнес дэх төрийн оролцоог

бууруулан, зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг босгох нь нэн чухал юм. Бидний амьдралд, хэвлэлд болон УИХ-ын танхимд гадны хөрөнгө оруулагчийг занаж зүхэх нь зайлшгүй байх процесс мэт болжээ. Хэрэв алдаа гараад байвал үнэндээ энэ нь гаднын хөрөнгө оруулагчийн буруу биш хуулиа муу хянасан, эсвэл авлигаар амаа үдүүлж, ашиггүй гэрээ хэлцэл хийсэн манай улстөрчдийн буруу билээ.

## Дүгнэлт

Энгийн боловч нухацтайгаар нэг санааг танд ойлгуулах гэж дээр хичээлээ. Орлого олж байгаа салбараа алж болохгүй гэж. Үүнийг германчууд алтан өндөг гаргадаг тахиагаа алах гэж хэлдэг. Тахиагаа алчихаад өндөггүй үлдэж болохгүй гэсэн үг л дээ. ■

# “COAL MONGOLIA-2013” тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллахаар боллоо

“COAL MONGOLIA-2013” Нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэнг гурав дахь жилдээ зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байгаа билээ. Энэ удаагийн чуулга уулзалт шинэчлэлийн Засгийн газар бүрэлдсэний дараа зохиогдож буйгаараа ихээхэн онцлогтой юм. Уламжлал ёсоор албан ёсны зохион байгуулагчаар Уул уурхайн яам, Монголын уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан Mining.mn хамтран зохион байгуулах бөгөөд Монголд үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллана. Одоогийн байдлаар энэ удаагийн чуулга уулзалтын платинум ивээн тэтгэгчээр нүүрсний салбарт тэргүүлэгч үндэсний компани болох “Mongolian Mining Corporation”, даймонд ивээн тэтгэгчээр “Хүннү Коал” хамтран ажиллах бол алтан ивээн тэтгэгчээр “Эрдэнэс Тавантолгой”, “ХасБанк”, “Жемком”, “Гложекс”, “Аспайр Майнинг”, “Терра Энержи”, албан ёсны банкны ивээн тэтгэгчээр “Худалдаа хөгжлийн банк” ажиллах юм байна. Чуулга уулзалт, үзэсгэлэнгийн үйл ажиллагааны ивээн тэтгэгчээр “Моннис интернэшнл”, “Трансвэст Монгол”, Хаан банк, “Вагнер Ази тоног төхөөрөмж”, “Майнз Ап”, “CARHARTT”-ын монгол дахь албан ёсны борлуулагч “Аянчин Аутфиттерс”, албан ёсны техникийн ивээн тэтгэгчээр “Мобинэт” зэрэг компани оролцохоор болсон нь зөвхөн уг чуулган бус Монголын нүүрсний салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж



буй хэмээн зохион байгуулагчдын зүгээс үнэлж байгаа аж. Чуулганд албан ёсны дэмжигч байгууллагын үүрэг маш чухал байдаг. Тэгвэл энэ удаагийн дэмжигч байгууллагаар МУУҮА, Монголын бизнесийн зөвлөл, Монголын уул уурхайн клуб, “ЗаЗа Корпорэйт Консел”, Хойд Америк Монголын бизнесийн зөвлөл зэрэг байгууллага хамтран ажиллаж эхэллээ. Чуулга уулзалтыг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ямар ч байгууллага ивээн тэтгэх боломжтой гэдгийг зохион байгуулагчид онцолж байлаа.

Та “COAL MONGOLIA-2013” чуулганы тухай дэлгэрэнгүй мэдээллийг 70115590 утсаар болон [www.coalmongolia.mn](http://www.coalmongolia.mn) сайтаас үзэж болох аж. ■

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

# Д.БАТ-ОЧИР: МАНАЙХ САЛБАРТАА ТЭРГҮҮЛЭГЧ БАЙХЫГ ЗОРИНО

Хасбанкны гүйцэтгэх захирал Д.Бат-Очиртой банкны салбарын засаглал, ниймгийн хариуцлагын талаар ярилцлаа.



**-Манай улсын арилжааны банкуудын засаглал ямар байна вэ. Тухайлбал, ХасБанкны засаглалын бусад арилжааны банкнаас ялгарах онцлог нь юу вэ?**

-Засаглалын хувьд арилжааны банкны хувьд ийм байх ёстой, аж ахуйн нэгжийн хувьд тийм байх ёстой гэсэн том зааг байхгүй гэж боддог. Засаглал гэдэг нь гүйцэтгэх удирдлага, ТУЗ (төлөөлөн удирдах зөвлөл), хувь нийлүүлэгчдийн үүрэг хариуцлагын зааг ялгааг оновчтой тогтоож тууштай хэрэгжүүлэх гол зорилготой байдаг болов уу. Шийдвэрүүд нь түвшин түвшиндээ гарна. Аль нэг нь нөгөөгийнхөө хариуцлага хүлээх шийдвэрийг өмнөөс нь гаргахгүй, бие биенийхээ ажилд хутгалдан орохгүй байх, хариуцлагын тогтолцоо нь хараат бус оновчтой байх нөхцөлд шийдвэрүүд нь илүү оновчтой, тогтвортой байж бодлогын залгамж халааг бий болгодог.

ХасБанкны хувьд 1998 оноос буюу жижиг төслийн хэмжээнд байгуулсан үеэсээ хэн, ямар шийдвэр гаргах вэ гэдэг ялгааг гаргаж ирсэн. Түүнийхээ дагуу тууштай явж байна. Үүнд ХасБанкны үе үеийн хувь нийлүүлэгчид гол нөлөө үзүүлсэн. Хувь нийлүүлэгчид л шийдвэр шат шатандаа гардаг, хараат бус байх, хяналттай байх боломжийг хангахгүй бол төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон удирдлагын баг тэр болгон хангаад байж чаддаггүй. ХасБанкны хувь нийлүүлэгчдийн хэн нэгэнд нь давамгайл эрх байхгүйгээс гадна өөрсдөө эрхэм зорилгынхоо төлөө нэгдсэн санаа зорилгоор ажиллаж чаддагаараа онцлог. Түүгээрээ бусад арилжааны банкаас ялгагддаг болов уу. Засаглалаа сайжруулаад явж буй банкууд зах зээл дэх байр сууриа бататгах бүрэн боломжтой.

**-Сайн засаглалтай байгууллагыг хэрхэн таньж мэдэх вэ?**

-Эхлээд санхүүгийн үзүүлэлтийг нь харах ёстой. Хэр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг юм бэ гэдэг нь санхүүгийн үзүүлэлтээс харагддаг. "Засаглал" гэдэг бол өөрөө биет бус ойлголт. Тоогоор илэрхийлэгддэг үр дүн тодорхой түвшинд засаглал нь зохистой байгаагийн нэг илэрхийлэл. Бас нэг чухал үзүүлэлт бол өмчлөлийнх нь бүтэц ямар байгааг харах ёстой. Энэ нь өөрөө ямар хувь нийлүүлэгчтэй байгууллага вэ гэдгийг харуулна. Хувь нийлүүлэгчид нь нэр хүндтэй хувь хүн, компани байгууллага бол тэдгээр хүмүүс хэзээ ч нэр төрөө сэвтүүлэхийг хүсэхгүй. Тэр утгаараа бий болгож, хөрөнгө оруулсан компанийнхаа төлөө санаа тавина. Дээр ▶

▶ нь ТУЗ-ийн төлөөллийг харах хэрэгтэй. ТУЗ нь өөрөө бэлгэдлийн чанартай сонгогдсон хүн байна уу эсвэл тухайн салбартаа ажилласан нэр хүндтэй, чадвартай, хийсэн зүйлтэй хүн байна уу гэдэг чухал байдаг. Цааш нь илүү гүнзгийрүүлээд ТУЗ нь ажлаа хийж чадаж байна уу гэдгийг ч харж болно. Мэргэшсэн хороод байна уу. Түүнчлэн санхүүгийн үзүүлэлтээ ил тод тайлагнадаг байгууллага мөн үү. Хөндлөнгийн хяналт хэр тавигддаг юм гэх мэтээр олон талаас харах нь зүйтэй.

ХасБанкны хувьд өөрсдийгөө жижиг гэж гололгүйгээр 2000 оноос эхлээд дэлхийд алдартай дөрвөн том аудитын компаниар санхүүгийн тайландаа хяналт хийлгүүлж хэвшсэн. Бид итгэлтэй гэж хэлээд харилцагчдынхаа итгэлийг олж авдаггүй. Хөндлөнгийн хяналт хийлгэж, үнэлгээ тавиулж байж олж авдаг. Түүний хажуугаар ХасБанк Монгол Улсынхаа бусад арилжааны банктэй харьцуулахад хамгийн олон буюу гадаадын 30 гаруй зээлдүүлэгчидтэй харилцдаг. Тэдгээр байгууллага нь зээл өгөхдөө ХасБанкны нэрэнд юм уу, эсвэл хувь нийлүүлэгчдэд нь болж зээл өгдөггүй. Газар дээр нь ирж судална, уулзаж ярилцана, ХасБанкны санхүүгийн үзүүлэлтүүдтэй танилцана. Түүнчлэн харилцагчидтай уулзалт хийдэг. Энэ нь өөрөө хөндлөнгийн давхар үнэлгээ болчихдог юм. Үүнээс гадна бид саяхан “Нийгмийн хариуцлага”-ын аудитыг анх удаа хийлгэлээ.

**-Нийгмийн хариуцлагадаа хөндлөнгийн хяналт хийлгэнэ гэдгээ тодруулахгүй юу?**

-Францад төвтэй “Планет Рейтинг” гэдэг байгууллагаар нийгмийн хариуцлагадаа хөндлөнгийн хяналт хийлгэсэн. Нийгмийн хариуцлагын үнэлгээний хүрээнд тухайн байгууллагын ажиллагсдын хүйсийн харьцаа, ажиллагсад болон нийгэмд чиглэсэн арга хэмжээ нь хэр өгөөжтэй юм гэх мэтээр судлаад ажиллагсад, нийгмийн хариуцлагын үйл ажиллагааны үр шимийг хүртэгсэдтэй уулзаж, ярилцаж ажиглалт хийгээд дүгнэлтээ гаргадаг юм.

**-Нийгмийн хариуцлагын үнэлгээг өмнө нь манай улсын аль нэг банк, байгууллага хийлгэж байсан болов уу?**

-Хийлгэж байгаагүй юм билээ. Манай улсын хувьд маш шинэлэг үнэлэмж. Дан ганц манай улсад гэлтгүй дэлхий нийтийн хувьд харьцангуй шинэлэг зүйл болж байгаа. Үнэлгээний хувьд дээд үнэлгээг онц сайн гэж үзвэл бид онц гэсэн үнэлгээ авсан.

**-Арилжааны банкууд нийгмийн хариуцлагатай гэж сурталчилж байна. ХасБанкны хувьд хийж буй нийгмийн хариуцлагын ажлуудаас алийг нь онцлох вэ?**

-Арилжааны банкууд нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна. Мянга гаруй хүн ажиллуулж байна гэдэг нь өөрөө нийгмийн хариуцлагын илэрхийлэл юм. Найдвартай татвар төлөгч байна гэдэг бас нэг нийгмийн хариуцлага болдог. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө бусдын адил боломжоороо санаа тавин ажилладаг. Бусад арилжааны банкнаас ХасБанкны хувьд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд давуу гэж хэлж болох нэг зүйл бол байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил.

Байгаль орчинд ээлтэй хэрэглээг бий болгох, үйлдвэрлэлийг дэмжих “Эко” банкны нэгжийг бий болгоод 2011 онд өргөжүүлсэн. Өнгөрсөн жил “Цэвэр агаар” төслийн хүрээнд байгальд ээлтэй 40 мянган зуухны түгээлтийн ажилд гол үүрэгтэй оролцлоо. Энэ зуухыг тавьснаар нэг айлын түлшний хэрэгцээ 30-50 хувь буурсан нь мөнгөн зардал болон хорт утааг тэр хэмжээгээр багасгасан. Энэ бол шууд утгаараа мэдрэгдсэн, нийгэм рүү чиглэсэн үр нөлөөтэй ажил юм. Хөгжиж буй жижиг улсын нэг банк нь агаарын бохирдлыг бууруулаад, түүнийгээ өндөр хөгжилтэй улсуудад зараад эхэлж байна гэдэг нь Монголд төдийгүй дэлхийд анхдагч болж байгаа юм.

Дээр нь хүүхдэд чиглэсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Голландад төвтэй “Афлатон” гэдэг байгууллагатай хамтран тухайн оронд туршигдсан санхүүгийн боловсролыг төрийн бус байгууллагатай хамтраад цөөнгүй сургуулийн сурагчдад олголоо. Энэ хөтөлбөрөөр дамжуулан 30.000 гаруй хүүхдэд санхүүгийн боловсрол олгоод байна. Тухайн сургалтад хамрагдсан хүүхдэд бүр манай харилцагч байх албагүй л дээ. Сургалтад хамрагдсан

хүүхдүүд санхүүгийн хариуцлага, зээл гэж юу болох, орлогоо яаж үр ашигтай зарцуулах, өрхийн төсвөө хэрхэн үр дүнтэй хөтлөх гэх мэт амьдралдаа өдөр тутам хэрэглэх зүйлүүдийг сурдаг. ХасБанкинд “Хөгжлийн алтан сан” гэж төрийн бус байгууллага байдаг. Түүнд манай ажилчид хувиасаа хандив өргөдөг. Уг хандивыг нь санхүүгийн тусламж хэрэгтэй байгаа авьяаслаг хүүхдүүдэд авьяасаа хөгжүүлэхэд нь туслахаас гадна нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа зарцуулдаг. Манай ТББ 2003 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

**-Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлд Монголбанк хуримтлалыг дэмжихээр тусгасан. Харин ХасБанк “ХасЛотто” аянаараа хуримтлалыг дэмждэг. Үүнийг Монголбанк хэрхэн урамшуулдаг вэ?**

-Монголбанк аль нэг банкныг хуримтлал дэмжих зорилгоор тусгайлан урамшуулдаггүй. Ингэх нь ч буруу. Харин, дунд болон урт хугацаатай эх үүсвэрийг бий болгох зорилгоор дотоодын хуримтлалыг идэвхжүүлэх, дэмжих тодорхой бодлого авч хэрэгжүүлж байна. Үүнд нь банкууд идэвхтэй оролцоод, зохицуулагч байгууллага нь бодлогоор дэмжээд явбал хуримтлал бий болгох дохио нь ч иргэдэд цэгцтэй очих байх. Аль нэг арилжааны банкны хуримтлал татах бодлого гэхээсээ илүүтэйгээр эдийн засгийн хувьд ч, хувь хүнд ч ач холбогдолтой арга хэмжээ юм шүү гэдгийг нийтэд ойлгуулах нь чухал.

**-ХасБанкны 15 жилийн түүхэндээ олсон олон амжилт байдаг. Олон амжилтынхаа хамгийн голыг нь нэрлээч гэвэл Та юу хэлэх вэ?**

-Бид анх Монгол Улсдаа бичил санхүүгийн бизнесийг хөгжүүлэх зорилготойгоор ажлаа эхлүүлж байлаа. Одоо бол системийн хэмжээний топ таван банкны нэг төдийгүй байгууллагын хувьд насанд хүрч байгаа улс орондоо ачааны хүндээс нь үүрэлдэг тулхтай байгууллага болсон байна. Энэ нь гол амжилт болов уу. Ийм байгууллага болсноороо бид маш олон амжилт гаргаж, гадаад, дотоодын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөн хүндлэлийг хүртэж ирлээ.

**-Танай хувь нийлүүлэгчдийн хувьд гадаадын байгууллага, ▶**

НОМИН НОМИН



“Номин Холдинг” компанийн амжилт олоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн 4300 ажиллагсад, тэдний гэр бүлийнхэнд, нийт хэрэглэгч, харилцагч түншүүд та бүхэндээ шинэ жилийн мэнд хүргэе.

*Мөнх НОМИН тэнгэр доор  
Төрийн алтан сүлд ивээж  
Энх НОМИН дэлхий дээр  
Буяны цагаан хишиг дэлгэрч  
Айсуй оны өдөр болгон тань НОМИН эрдэнийн хуудсаар эргэж  
Амжилт ололт бүхэн тань НОМИН өнгөөр туяарч байх болтугай*

“НОМИН ХОЛДИНГ” КОМПАНИЙН  
ЕРӨНХИЙЛӨГЧ Ш.БАЯРСАЙХАН

## БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ

Улиран одож буй 2012 онд бид үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойгоо амжилт бүтээл өндөртэй тэмдэглэн өнгөрүүлж байна. Бүтэн жилийн туршид хүндэт хэрэглэгчид, дотоод, гадаадын харилцагч түнш байгууллагууд болон Номинчуудаа баярлуулах томоохон үйл ажиллагааг зохион явуулсныг тэмдэглэхэд таатай байна.

- ✦ 8438 хүнийг азтан болгох 2 тэрбум төгрөгийн шагналын сантай ТЭРБУМТАН бэлэгтэй, сугалаат худалдааг зарлаж электрон бараа, Шевролет автомашин, Өнөр хорооллын орон сууц зэрэг олон хонжворуудыг өгч хэрэглэгч худалдан авагчдаа баярлуулж байна.
- ✦ Улсын баяр наадмын өдрүүдэд хамтран ажилладаг гадаадын түншүүдээ Монголд урьж, ТӨРСӨН ӨДРИЙН БАЯРАА хамтдаа тэмдэглэн өнгөрүүлсэн.
- ✦ 9 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд байгалийн үзэсгэлэн бүрэлдсэн “Хустайн Нуруу”-нд НОМИН-НААДМАА халуун ам бүлээрээ цуглаж хийлээ.
- ✦ Саяхан 12 дугаар сарын 01-ний өдөр дотоодын харилцагч түншүүдээ хүндэтгэл үзүүлж “ТАЛАРХЛЫН ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулж хамтдаа нэгэн үдшийг өнгөрүүлээ. Талархлын өдөрлөгт Төр, Нийгмийн зүтгэлтэн, Элчин сайдууд, урлаг, соёл, спортын алдартан төлөөлөгчид хүрэлцэн ирж бидний баярт мөчийг хуваалцлаа.
- ✦ Энэ онд улсын төсөвт 36 тэрбум төгрөгийн татвар шимтгэлийг төлсөн нь өмнөх оныхоос 41%-иар өссөн байна. Худалдааны борлуулалт үйлчилгээ 48%, Бүтээгдэхүүн үйлдвэрлэл 6,5-25%, Өөрийн хөрөнгийн өгөөж 26%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Баянзүрх дүүрэгт 8500 м<sup>2</sup> талбай бүхий орчин үеийн бөөний худалдааны төв, 13-р хорооллын Номин Хайпермаркетын өргөтгөл, Сонгинохайрхан дүүрэгт орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл бүхий Хүнс, Химийн лаборатори ашиглалтанд оруулж байна. Өнөр хотхоны 340 айлын III, IV байр, Ривер гарден хотхонд 68 айл, 8 хаус, Эрдэнэт хотод 82 айл, нийт 500 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан амжилтаар шинэ оноо угтлаа.



### ▶ хувь хүмүүс байдаг. Гадаад хувь нийлүүлэгчийн давуу ба сул тал нь юу вэ?

-Хувь нийлүүлэгч нь гадаад эсвэл дотоод байх нь чухал биш. Харин оруулж буй хувь нэмэр нь гол гэж бодож байна. Стратегийн буюу идэвхтэй хувь нийлүүлэгч гэж байна. Санхүүгийн хувь нийлүүлэгч гэж бий. Санхүүгийн хувь нийлүүлэгч нь мөнгөө та нар тодорхой хэмжээгээр өсгөж өгөөрэй гээд өгч байдаг. Бидний хувьд стратегийн болон санхүүгийн хувь нийлүүлэгчдийн аль аль нь байгаа бөгөөд хамгийн гол нь тэд зохистой засаглалыг эрхэм болгон өөр, өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж байгаа нь амжилттай ажиллахын үндэс болдог болов уу. Хувь нийлүүлэгчид засаглалын зөв бүтэц бий болгож байна. Шаардлагатай үед хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. Санхүүгийн хувьд мэдлэгтэй хувь нийлүүлэгчид туршлагаа хуваалцахын хажуугаар сайн туршлагыг байгаа газраас нь олж ирээд ХасБанкны хөрсөн дээр суулгаж

байна. Мөнгөнөөс гадна байгууллагын чадавхийг дээшлүүлж тогтвортой байлгахад тусалдаг. ХасБанк сүүлийн 14 жил системдээ өсөлтийн хурдаараа тэргүүлээ. Сүүлийн дөрвөн жилийн дотор шилдэг таван банк дотроо бид зээл, хадгаламжийн үйл ажиллагаагаараа тэргүүлж байна. Энэхүү өсөлтийг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хангана гэдэг бол их чухал.

**-ХасБанк томоохон, дундаж, жижиг гээд бүх төрлийн харилцагчтай болсон байна. Энэ нь томоохон стратеги байв уу?**

-Одоогоос 14 жилийн өмнө өнөөдрийн энэ түвшинд хүрэх юм гэж төсөөлж байсангүй. Гэхдээ өрсөлдөх чадвартай сайн байгууллага болохын төлөө гэдэг ерөнхий зорилт бол байсан. Тухайлбал, 1998 онд төслийн үйл ажиллагаа дөнгөж эхлээд удаагүй байхдаа л арилжааны банк болох нь илүү оновчтой юм байна гэдэг дээр санал нэгдэж байсан байдаг. Тэр үед байгууллагын чадавхийг бий болгохыг зорьж байлаа. Өнөөдөр ч энэ

зорилгынхоо төлөө явж байна. Үр дүн, тоо бол чадварыг дагадаг. Зохиомлоор үр дүн бий болгочихоод түүнийгээ барьж чадахгүй бол бизнес биш. Сайхан зар сурталчилгаа явуулаад олон харилцагчид татчихаад сайн үйлчилгээ үзүүлж чадахгүй бол өрсөлдөөнөөс хасагдана.

Энэ утгаараа бид гурав, таван жилээр бизнесээ төлөвлөхдөө аль болох байгууллагынхаа ажиллагсад, хувь нийлүүлэгчид, ТУЗ зэрэг бүх түвшинд оролцон, чадавхи бий болгох, зах зээлээ тэлэх зорилтуудаа уялдуулж байсан нь ХасБанкыг өдий зэрэгт авчирсан. Тухайн цаг үед ажиллаж байсан хамт олон өөр өөрсдийнхөө ачааг нүүр улайхгүйгээр үүрээд явж байсны ач гавьяа юм. Бид ч цааш нь үүрч байгаа ачаагаа ирээдүй үедээ өгнө. Тэр үед нүүр бардам байх хэрэгтэй. Ийм учраас ХасБанк салбартаа ямагт тэргүүлэгч нь байхыг зорино.

**-Ярилцлага өгсөн танд баярлалаа. ■**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

# ӨВЛИЙН ӨВӨӨГӨӨС ТЭД ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ХҮСЭХ БАЙХ ДАА

Б.УУГАНБАЯР

...Монголын компаниудад дотоод аудит хийх, үйл ажиллагаагаа хянаж, шалгадаг тогтолцоо байдаггүйгээс компанийн эрх мэдэл зөвхөн эзний гарт төвлөрч, засаглал нь “догolon” явна...

**Ш**инэ жилийн баяраар хүн бүхэн сайн сайхан зүйлийг хүсэж, хүүхэд, багачууд өвлийн өвөөд хүслээ нууцхан “дайж”, бүх зүйл сайхан болно гэдэгт итгэдэг. Тэгвэл компанийн захирлуудад өвлийн өвөөгөөс ямар нэг зүйл хүс гэвэл өндөр боловсролтой, чадварлаг, зөв төлөвшсөн, өв тэгш гүйцэтгэх захирал хүсэх байсан гэдгээр би тантай мөрийцөхөд ч бэлэн байна. Учир нь, манай бизнесийн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, компаниуд ч засаглалаа бэхжүүлэхэд анхаарах болсон. Хэрэв компанийнх нь ашиг орлого тааруу, нэг л “явж” өгөхгүй бол засаглал муутай байна гэсэн үг. Бизнесийн салбарт компанийн засаглалыг сайжруулахтай холбоотой олон асуудал бий. Үүний дотроос компанийн эздийн толгойны өвчин болсон асуудал бол сайн гүйцэтгэх захиралтай болох. Амьдралын ойрхон жишээнээс харъя л даа. Тухайлбал, хэн нэгэн бизнесмэн өөрийн ажлаа өөр хүнд шилжүүлж, улс төрийн эсвэл өөр салбарт ажиллах нь олонтаа. Энэ үед зарим нь үр хүүхэд, хамаатан садандаа ажлаа даалгачихаар загная загнаж болдоггүй, хэлэлцье хэлэлцэж болдоггүй хэцүү байдалд ордог тухай “Орбит комплекс” компанийн зөвлөх Ц.Хүрэлбаатар учирласан нь олон захирлын зовлон байх. Эдгээр шалтгааны улмаас л компаниуд өдөр тутмын үйл ажиллагааг нь удирдаж компанийг зөв залж явах гүйцэтгэх захирлын эрэлд хатдаг байна. Тэгэхээр сайн гүйцэтгэх захирлыг олох, олсноо тогтооход итгэлцэл, ойлголцоолоос эхлээд олон асуудал урган гардаг.

## Гүйцэтгэх захирал яагаад олддоггүй вэ?

Үүнд олон шалтгаан бий аж. Монголд бизнесийн салбар үүсэж, хөгжөөд 20-иод жил болж буй учир хүний мөнгөн дээр ажиллаж ирсэн туршлагатай гүйцэтгэх захирал бараг байхгүйг Компанийн засаглалын хөгжлийн төвийн ерөнхий нарийн бичгийн дарга Т.Цэнд-Аюуш онцолсон. Бизнесийн ертөнцийн томчууд өөрийн хичээл зүтгэлээр компаниа хөл дээр нь босгож, өдий зэрэгтэй явуулж байгаа болохоос хүний компанийг удирдаж байсан туршлагатай хүн цөөхөн гэдэг нь үнэн. Харин туршлагатай хэдэн гүйцэтгэх захирлаа Монголын компаниуд булаацалддаг байна. Өндөр хөгжилтэй орнуудад гүйцэтгэх захирлыг томилох, ажиллуулах соёл манайхаас их өөр. Тиймээс ч гүйцэтгэх захирлын үнэлэмж өндөр, компанийн үйл ажиллагааг нь сайн авч явдаг гэдгийг тэрбээр хэлсэн. Гэтэл

Монголын компаниудад дотоод аудит хийх, үйл ажиллагаагаа хянаж, шалгадаг тогтолцоо байдаггүйгээс компанийн эрх мэдэл зөвхөн эзний гарт төвлөрч, засаглал нь “догolon” явна.

## Мэдээлэлтэй хүн л зөв сонголт хийдэг

Тиймээс манай компаниудын удирдлага гүйцэтгэх захирлаа сонгохын тулд өөрөө засаглалын талаар мэдлэг, мэдээлэлтэй болох нь чухал гэдгийг Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга, Санхүүгийн ▶



Шог зургийг А.Амарсайхан

► зохицуулах хорооны гишүүн Д.Ганбаяр дурдсан. Бизнесийнхэн болон холбогдох хүмүүсийн ярианаас үзэхэд, компанийн захирлууд ихэвчлэн олон жил ажилласан, банк санхүүгийн асуудлыг мэддэг хэмээн нягтландаа компаниа даатгах нь элбэг гэнэ. Гэтэл нягтлан нь компаниа гадаад зах зээл дээр таниулах, цаг үетэйгээ хөл нийлж алхах чадвар дулимаг байдаг аж. Эсвэл гадаадад их, дээд сургууль төгссөн, өндөр боловсрол мэдлэгтэй мөртлөө сэтгэлгүй хүн авчирвал эзний толгойноос гүйцэтгэх захирлын толгой давж ажиллаад компанийг нь дампууруулах нигууртай байдаг гэх. Иймээс л компанийн эздүүд “Гунхсан нэг нь намайг тоохгүй, гутлаа чирсэнийг нь би тоохгүй” гэдэг шиг ухаантай хүн авах хэцүү, байх хэцүү шаналж явдаг бололтой.

## Итгээд үз

Компанийн эзэд гүйцэтгэх захиралдаа санхүүгийн эрх мэдэл өгч, өдөр тутмын үйл ажиллагаа удирдах эрхийг өгөлгүй гарын үсэг зурдаг “утсан хүүхэлдэй” болгох сонирхол их байдгаас чадвартай залуучууд энэ албаас зугтдаг гэдгийг “Гүйцэтгэх захирлуудын клуб”-ын зохицуулагч Б.Сайнбаяр сануулсан юм. “Тогтоол ус өмхийрдэг” гэдэг шиг хэчнээн эрдэм

мэдлэгтэй ч хүн өөрт сонирхолгүй, ахиц дэвшихгүй ажил хийхийг хүсэхгүй. Урам зориг ч төрөхгүй нь мэдээж. Гарын үсэг зурдаг нэр төдий л байхыг хэн ч хүсэхгүй. Манайд компанийн эзэн гүйцэтгэх захирал хоёрын хоорондын итгэлийг баталгаажуулахад хянаж, шалгадаг тогтолцоо байхгүйгээс бие биедээ итгэнэ гэдэг хүнд даваа болоод байгаа юм. Энэ итгэлийг бий болгохын тулд наад зах нь гүйцэтгэх захиралтай ажил, үүргийн хуваарийг нь бичгэн хэлбэрээр гэрээ байгуулж, эрх мэдлийг өгөх хэрэгтэй гэдгийг судлаачид сануулдаг. Дээр нь гүйцэтгэх захирлаа хөшүүрэгдэх цалин урамшуулал болон бусад нөхцөлийг бий болгох хэрэгтэй аж. Хэрэв компанийн эзэд эхлээд өөрсдөө мэдээлэлтэй болчихоод зөв хүнээ сонгоод, харилцан итгэлцэж, хяналтын тогтолцоогоо нарийн бүрдүүлж ажиллавал компанийн засаглал сайжирч, үйл ажиллагаа нь өнгө орон гялалзах нь тодорхой. Тэгэхээр эзэд өвлийн өвөөгөөс гүйцэтгэх захирал хүсэх биш, сайн гүйцэтгэх захиралтай болох эрэл хайгуул хийж, зөв хүнээ олж, олсон хүндээ итгэл хүлээлгэх боломжийг бий болгохын төлөө ажиллах хэрэгтэй. Сайн засаглалтай компани томоохон хөрөнгө оруулалт татаж, зах зээлээ өргөжүүлэх боломж нээлттэй байгаа энэ сайхан үеийг компаниуд алдах ёсгүй. ■

САЙН ТУРШЛАГА

# ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧНЫ СТАНДАРТАА ШИНЭЧИЛНЭ

“ДАРХАН ХҮНС” ХХК

## Төлөөлөн удирдах зөвлөл:

(ТУЗ нь нийт есөн гишүүнтэй үүнээс гурав нь хараат бус)

### ТУЗ-ийн гишүүд:

1. Д.Бат-Эрдэнэ
2. С.Оюунчимэг
3. Б.Бат-Өлзий
4. Б.Батнасан
5. Б.Мягмарсүрэн
6. С.Дорж

### ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Т.Цэвэгмэд
8. Т.Өлзийсайхан
9. Төмөрбаатар

### Гүйцэтгэх захирал: Тунгалагийн Алдар

Эдийн засагч мэргэжилтэй



Хүнсний үйлдвэрлэлийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхийн тулд HACCP, ISO зэрэг стандартуудыг нэвтрүүлж байна.

## Ажлын туршлага:

- 2000-2005 онд “НЛМ” Норвегийн байгууллага төслийн менежер
- 2008 оноос одоог хүртэл “Дархан хүнс” компанийн гүйцэтгэх захирал

## Гол бизнес:

Талх, нарийн боов, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа

## Компанийн засаглалаа сайжруулах чиглэлээр хийж буй шинэчлэл:

Хүнсний үйлдвэрлэлийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхийн тулд HACCP, ISO зэрэг стандартуудыг нэвтрүүлж байна.

## Хувьцаа эзэмшигчдийн тоо: 897

## Санхүүгийн товч тайлан:

### Он Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)

Цэвэр ашиг	Нийт хөрөнгө оруулалт (сая төгрөг)	
2010 1.0	11.1	329
2011 1.4	19.7	331

Он	Бүтээгдэхүүний борлуулалт (тэрбум)	Өсөлтийн хувь (өмнөх онтой харьцуулсан)
2010	1.1	37.0
2011	1.5	30.2
2012	2.2	28.0

## Компанийн голлох үзүүлэлтүүд

	2006 онд	2012 онд
Үндсэн ажилчдын тоо	65	150
Харилцагчдын тоо	210	976
Бүтээгдэхүүний нэр төрөл	25	56
Борлуулалтын үйлчилгээний машины тоо	4	15
Эргэлтийн хөрөнгө /сая төгрөг/	48	360.0
Нийт татвар төлөлт /сая төгрөг/	20.5	128.4


## Компанийн засаглалыг хөгжүүлэхийн тулд юуг анхаарах

Татварын орчинг шударга, ил тод, нээлттэй болгох.

# Шинэ оны тэнд хүрээе!



## Nano Planet



- Бохирдлыг самнаж гаргах,
- Ухах,
- Овоолгыг түрэх,
- Усанд шон суулгах



Хаяг:  
Улаанбаатар хот,  
БГД 10-р хороолол,  
6-р хороо,  
Дилавхутагт  
Жамсранжавын  
гудамж,  
3-р байшин

Утас:  
8809-6648  
88116648,  
99006648,  
88016648

Вэб хаяг:  
<http://nano.planet-mongolia.com/>

[info@planet-mongolia.com](mailto:info@planet-mongolia.com)